



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/17/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан Утас:261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас:323266 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Ахлах аудитор: Ш.Наран Утас:323266 Цахим хаяг: naransh@audit.gov.mn Аудитор: Т.Нямсүрэн Утас:323266 Цахим хаяг: nyamsurent@audit.gov.mn Аудитор: Э.Цэлмэгбаяр Утас:323266 Цахим хаяг: tselmegbayare@audit.gov.mn
---	---

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа	13
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.6 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл	26
4. АУДИТЫН ТАЙЛАН	28
4.1 Ерөнхий зүйл	28
4.2 Материаллаг байдал.....	28
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	28
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	29
Төсвийн ерөнхийлөн захирагч.....	29
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	31
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	31
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	31
5.1 Харьяа байгууллагууд.....	32
5.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан	33
5.2.1 Албан шаардлага	33
5.3 Түүврийн байгууллага.....	34
5.3.1 Төлбөрийн акт.....	34
5.2.2 Албан шаардлага	35
5.2.3 Зөвлөмж	42
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	48

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БТСУХ	Биеийн тамир, спортын улсын хороо
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ССАЖЗС	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
СУГ	Соёл урлагийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН САЙД Ж.АЛДАРЖАВХЛАН
ТАНАА

2026.04.27 № 1156
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу аудит хийгдэх байгууллагаас хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний олж авсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 165,874.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Урьдчилж төлсөн зардлын дансанд 2022 онд бүртгэгдсэн соёлын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж нийлүүлэх 294.4 сая төгрөг, GLAM систем хөгжүүлэх, сургалт зохион байгуулах, сурталчилгаа хийх зөвлөх үйлчилгээ 225.0 сая төгрөг, нийт 516.0 сая төгрөгийн гэрээний төлбөрийг бүрэн санхүүжүүлсэн, гэрээний хугацаа дууссан, ажил үйлчилгээний гүйцэтгэл болон тоног төхөөрөмж нийлүүлсэн эсэх нь тодорхойгүй, тооцоо нийлсэн актгүй, арга хэмжээ авч ажиллаагүй;

- Төвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт нийт 195.4 сая төгрөгийг цалингийн зардлаас олгосон бөгөөд буруу шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтнаас төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлээгүй;
- Бусад эргэлтийн хөрөнгө дансанд санхүүжилт авсан боловч дуусгаагүй царцсан барилга, өмнөх онуудад улсын комиссын дүгнэлт гарч, ашиглалтад оруулсан барилга байгууламж, тоног төхөөрөмжийг эрх бүхий байгууллага албан тушаалтнаар шийдвэр гаргуулан ашиглагч байгууллагад шилжүүлээгүй зэрэг нийт 120,582.4 сая төгрөгийн зөрчил илэрсэнтэй холбоотой хөрөнгийн ашиглалт хамгаалалт, бүртгэлийн асуудалд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй;

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 15 дугаар зүйлийн 15.4, 15.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 24-ийг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Толилуулга ба тодруулга", "Эрх ба үүрэг", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Азийн сторителлингийн хорооны 17 дахь удаагийн хурлыг Монгол Улсад анх удаа амжилттай зохион байгуулж, гишүүн орнуудын домог, түүх, баатарлаг туульсыг хүүхдийн ном, жүжиг, хөгжимт жүжиг, дижитал контент хэлбэрээр олон улсад түгээн дэлгэрүүлэх хамтын ажиллагааны асуудлыг хэлэлцэж, арга хэмжээний зохион байгуулалтад 72.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Парис хотноо болсон ёслолоор Францын хууль сахиулах байгууллагаас 2013, 2015 онд хураасан, Монголын говиос гаралтай нь тогтоогдсон бөгөөд шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой тарбозаврбатаар үлэг гүрвэлийн чулуужсан олдвор бүхий 29 багцыг Монгол Улсад үнэ төлбөргүйгээр хүлээлгэн өгөхөөр баталгаажуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нийтийн эрх зүйн хуулийн этгээдтэй байгуулсан төрийн чиг үүрэг гүйцэтгүүлэх гэрээний хүрээнд олгосон 2,447.7 сая төгрөгийн санхүүжилтийн зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, гүйцэтгэгч тал тайлангаа ирүүлээгүй, олон нийтэд нээлттэй мэдээлээгүй байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартын дагуу хууль, тогтоомжийн хэрэгжилтэд нэмэлт горим, сорил гүйцэтгэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	639,250,564.5	630,650,775.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	27,005,164.1	5,012,953.0
33	АВЛАГА	8,791,449.6	13,246,850.5
34	УРЬДЧИЛГАА	8,541,559.0	6,560,404.4
35	БАРАА МАТЕРИАЛ	42,557,937.9	45,345,077.9
36	НӨӨЦИЙН БАРАА	369,507.7	384,786.5
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	551,984,945.9	560,100,702.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	922,116,469.2	1,041,888,870.2
2.1	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,000,000.0	1,000,000.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	921,116,469.2	1,040,888,870.2
39300	Биет хөрөнгө	878,543,756.5	991,740,397.0
39303	Биет бус хөрөнгө	42,572,712.6	49,148,473.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	1,561,367,033.6	1,672,539,645.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,500,646.4	10,551,794.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,500,646.4	10,551,794.8
41300	Өглөг	4,460,229.4	10,540,997.5
41400	Урьдчилж орсон орлого		10,797.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,556,866,387.3	1,661,987,850.5
51	Засгийн газрын хувь оролцоо	1,556,866,387.3	1,661,987,850.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	209,028,795.5	215,208,707.6
51200	Хуримтлагдсан үр дүн	1,077,426,400.6	1,178,638,333.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	237,880,673.3	235,610,292.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,561,367,033.6	1,672,539,645.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	856,343,372.5	561,259,953.7
11	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	301,506,927.7	561,259,953.7
122	Тусламжийн орлого	1,720,952.2	435,062,179.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	554,836,444.8	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	418,531,841.1	404,445,198.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417,894,161.4	404,399,309.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	370,619,865.1	371,447,090.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,695,503.7	209,065,154.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	22,002,776.9	25,959,263.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,638,176.2	3,914,453.8
2104	Хангамж, бараа материалын зардал	7,695,517.6	6,954,589.7
2105	Нормативт зардал	628,984.4	383,919.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,765,285.4	1,640,604.4
2107	Томилолт, зочны зардал	2,247,707.4	1,332,535.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,578,878.3	47,670,771.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,367,035.2	74,525,799.4
	ТАТААС	802,099.1	1,037,487.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,472,197.2	31,914,732.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	637,679.7	45,888.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	437,811,531.5	156,814,755.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(62,658,594.3)	(53,968,895.5)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	375,152,937.2	102,845,859.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	973,777,508.0	973,777,508.0
2	Нягтлан бодох бүртгэлийн-бодлогын өөрчлөлт	208,076,792.3	208,076,792.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,181,854,300.3	1,181,854,300.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний-өсөлт бууралт	(344,728.8)	(344,728.8)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	239,688.7	239,688.7
6	Өмчид гарсан өөрчлөлт	(23,194.4)	(23,194.4)
7	Зарласан ногдол ашиг	(12,615.8)	(12,615.8)
8	Тайлант үеийн үр дүн	375,152,937.2	375,152,937.2
9	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,556,866,387.2	1,556,866,387.2
10	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,556,866,387.2	1,556,866,387.2
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,815,583.7	2,815,583.7
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,559,681,970.9	1,559,681,970.9
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,409,901.5)	(1,409,901.5)
14	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(293,799.3)	(293,799.3)
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(101,213.1)	(101,213.1)
16	Өмчид гарсан өөрчлөлт	119,341.6	119,341.6
17	Зарласан ногдол ашиг	(21,692.8)	(21,692.8)
18	Тайлант үеийн үр дүн	103,425,546.1	103,425,546.1
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,661,987,850.5	1,661,987,850.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	599,732,347.3	452,873,522.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	42,907,702.3	452,873,522.3
120	Нийтлэг татварын бус орлого	42,892,702.3	12,918,431.1
122	Тусламжийн орлого	15,000.0	439,809,517.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	556,824,645.0	0
13	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	401,704,389.9	361,628,714.4
II	УРСГАЛ ЗАРДАЛ	401,704,389.9	361,628,714.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	348,598,195.7	317,867,859.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,774,309.3	209,406,553.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,084,303.6	26,009,737.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,144,202.3	3,845,794.4
2104	Хангамж, бараа материалын зардал	5,240,164.2	3,471,958.8
2105	Норматив зардал	1,767,685.4	495,265.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,693,544.4	2,988,177.8
2107	Томилолт, зочны зардал	2,300,475.7	1,318,137.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	92,133,505.2	40,982,196.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,460,005.5	29,350,038.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,315,345.1	42,777,574.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	198,027,957.4	91,244,807.9
V	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	216,800,650.1	114,214,453.1
VII	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(216,671,424.4)	(114,085,239.9)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(19,750,032.9)	(22,919,018.0)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	46,755,197.1	27,005,164.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27,005,164.1	4,086,146.1

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	441,170,417,600.00	392,307,293,530.16	(48,863,124,069.84)	88.92
12	Татварын бус орлого	441,170,417,600.00	392,307,293,530.16	(48,863,124,069.84)	88.92
120	Нийтлэг татварын бус орлого	304,000,000.00	8,257,515,065.77	7,953,515,065.77	2716
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	304,000,000.00	4,850,747,839.70	4,546,747,839.70	1596
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	0.00	3,406,767,226.07	3,406,767,226.07	#DIV/0!
122	Тусламжийн орлого	440,866,417,600.00	384,048,779,751.89	(56,817,637,848.11)	87.11
122005	Төсвөөс санхүүжих	440,866,417,600.00	384,048,779,751.89	(56,817,637,848.11)	87.11
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	441,170,417,600.00	390,881,411,905.84	(50,289,005,694.16)	88.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	315,605,917,600.00	295,659,058,409.61	(19,946,859,190.39)	93.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	297,958,558,900.00	282,796,886,554.98	(15,161,672,345.02)	94.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,219,720,500.00	204,528,151,540.58	(5,691,568,959.42)	97.29
210101	Үндсэн цалин	120,889,049,300.00	122,487,612,025.98	1,598,562,725.98	101.3
210102	Нэмэгдэл	61,697,172,900.00	54,456,157,957.90	(7,241,014,942.10)	88.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,062,457,600.00	14,408,730,145.54	1,346,272,545.54	110.3
210104	Урамшуулал	14,525,917,500.00	13,085,227,686.71	(1,440,689,813.29)	90.08
210105	Гэрээт ажлын хөлс	45,123,200.00	90,423,724.45	45,300,524.45	200.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,342,150,600.00	25,239,468,543.95	(1,102,682,056.05)	95.81
210201	Тэтгэрийн даатгал	18,056,539,100.00	17,314,404,194.49	(742,134,905.51)	95.89
210202	Тэтгэмжийн даатгал	2,072,040,100.00	2,012,892,238.96	(59,147,861.04)	97.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,037,597,800.00	1,041,527,809.40	3,930,009.40	100.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,035,270,800.00	972,788,284.26	(62,482,515.74)	93.96
210205	Эрүүл мэндийн даатгал	4,140,702,800.00	3,897,856,016.84	(242,846,783.16)	94.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,006,042,800.00	2,904,690,260.12	(101,352,539.88)	96.63
210301	Гэрэл, цахилгаан	904,416,800.00	862,924,718.08	(41,492,081.92)	95.41
210302	Түлш, халаалт	610,184,700.00	595,726,882.72	(14,457,817.28)	97.63
210303	Цэвэр, бохир ус	203,529,900.00	187,381,859.32	(16,148,040.68)	92.07
210304	Байрны түрээс	1,287,911,400.00	1,258,656,800.00	(29,254,600.00)	97.73
2104	Хангамж, бараа материалын зардал	2,890,980,300.00	2,399,737,301.80	(491,242,998.20)	83.01
210401	Бичиг хэрэг	566,747,500.00	410,589,681.00	(156,157,819.00)	72.45
210402	Тээвэр, шатахуун	576,508,200.00	556,509,066.89	(19,999,133.11)	96.53
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	744,607,400.00	575,153,947.66	(169,453,452.34)	77.24
210404	Ном, хэвлэл	137,316,700.00	123,696,413.00	(13,620,287.00)	90.08
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	70,765,000.00	40,022,911.00	(30,742,089.00)	56.56
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	795,035,500.00	693,765,282.25	(101,270,217.75)	87.26
2105	Нормативт зардал	638,390,100.00	438,513,831.00	(199,876,269.00)	68.69

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	404,605,100.00	403,812,650.00	(792,450.00)	99.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	233,785,000.00	34,701,181.00	(199,083,819.00)	14.84
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,243,707,000.00	5,223,978,315.40	(1,019,728,684.60)	83.67
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,889,373,200.00	3,996,188,461.60	(893,184,738.40)	81.73
210602	Тавилга	779,505,100.00	711,883,799.99	(67,621,300.01)	91.33
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	26,331,500.00	13,710,900.00	(12,620,600.00)	52.07
210604	Урсгал засвар	548,497,200.00	502,195,153.81	(46,302,046.19)	91.56
2107	Томилолт, зочны зардал	903,927,600.00	719,413,047.50	(184,514,552.50)	79.59
210701	Гадаад албан томилолт	71,344,100.00	62,645,957.50	(8,698,142.50)	87.81
210702	Дотоод албан томилолт	832,583,500.00	656,767,090.00	(175,816,410.00)	78.88
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,913,733,500.00	28,892,225,351.16	(5,021,508,148.84)	85.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,323,609,100.00	28,624,231,386.13	(4,699,377,713.87)	85.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	221,312,600.00	80,618,568.00	(140,694,032.00)	36.43
210803	Даатгалын үйлчилгээ	31,623,800.00	7,191,994.40	(24,431,805.60)	22.74
210804	Тээврийн хэрэгслийн татвар	14,030,800.00	5,569,060.00	(8,461,740.00)	39.69
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	7,455,500.00	1,473,476.00	(5,982,024.00)	19.76
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,838,400.00	73,046,760.63	(59,791,639.37)	54.99
210807	Газрын төлбөр	175,601,600.00	95,852,876.00	(79,748,724.00)	54.59
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,261,700.00	4,241,230.00	(3,020,470.00)	58.41
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,799,906,500.00	12,450,708,363.47	(1,349,198,136.53)	90.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,731,716,100.00	12,382,808,223.47	(1,348,907,876.53)	90.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	68,190,400.00	67,900,140.00	(290,260.00)	99.57
212	ТАТААС	1,601,005,300.00	983,280,863.50	(617,724,436.50)	61.42
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,601,005,300.00	983,280,863.50	(617,724,436.50)	61.42
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,601,005,300.00	983,280,863.50	(617,724,436.50)	61.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,046,353,400.00	11,878,890,991.13	(4,167,462,408.87)	74.03
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	140,091,800.00	130,693,450.00	(9,398,350.00)	93.29
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	140,091,800.00	130,693,450.00	(9,398,350.00)	93.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,906,261,600.00	15,485,701,641.13	(420,559,958.87)	97.36
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,527,759,400.00	1,236,712,218.00	(291,047,182.00)	80.95

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,345,775,600.00	4,761,435,313.00	(1,584,340,287.00)	75.03
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,127,844,800.00	6,754,136,759.13	(373,708,040.87)	94.76
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,999,532,200.00	1,912,417,582.00	(2,087,114,618.00)	47.82
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	905,349,600.00	820,999,769.00	(84,349,831.00)	90.68
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	125,564,500,000.00	95,222,353,496.23	(30,342,146,503.77)	75.84
220001	Барилга байгууламж	121,994,500,000.00	91,874,293,618.23	(30,120,206,381.77)	75.31
222001	Тоног төхөөрөмж	2,973,700,000.00	3,348,059,878.00	374,359,878.00	112.6
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	1,425,881,624.32	1,425,881,624.32	
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,425,881,624.32	1,425,881,624.32	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	1,425,881,624.32	1,425,881,624.32	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	0.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	486	486		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	7,226	7,138	(88)	
620001	Удирдах ажилтан	403	387	(16)	
620002	Гүйцэтгэх ажилтан	3004	2731	(273)	
620003	Үйлчлэх ажилтан	3800	3416	(384)	
620004	Гэрээт ажилтан	17	26	9	
650011	Улс төрийн албан хаагч	2	2	0	

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	51,958,114,296.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,958,114,296.14
122	Тусламжийн орлого	51,958,114,296.14
1221	Хандив тусламж /дотоод/	51,958,114,296.14
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,958,114,296.14
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	788,490,780.94
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,649,006,851.12
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,175,538,424.36
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	18,345,078,239.72
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,550,488,162.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,550,488,162.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,585,347,712.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,539,849,716.47
210101	Үндсэн цалин	1,557,903,691.22
210102	Нэмэгдэл	1,643,866,054.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	68,716,628.67
210104	Урамшуулал	266,478,342.50
210105	Гэрээт ажлын хөлс	2,885,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	413,945,233.14
210201	Тэтгэврийн даатгал	336,394,174.21
210202	Тэтгэмжийн даатгал	21,161,287.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,585,975.78
210204	Ажилгүйдлийн даатгал	9,161,714.70
210205	Эрүүл мэндийн даатгал	35,642,081.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	156,301,134.78
210301	Гэрэл, цахилгаан	112,361,177.18
210302	Түлш, халаалт	33,672,928.68
210303	Цэвэр, бохир ус	10,267,028.92
2104	Хангамж, бараа материалын зардал	1,091,340,544.41
210401	Бичиг хэрэг	104,735,213.00
210402	Тээвэр, шатахуун	301,732,530.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	52,793,419.43
210404	Ном, хэвлэл	16,130,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,432,743.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	585,516,638.98
2105	Норматив зардал	63,291,000.00
210502	Хоол, хүнс	16,178,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	47,112,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,069,315,076.69
210601	Багаж, техник, хэрэгсэл	436,497,378.00
210602	Тавилга	19,500,170.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	17,682,610.00
210604	Урсгал засвар	595,634,918.69
2107	Томилолт, зочны зардал	598,724,781.00
210701	Гадаад албан томилолт	165,371,197.00
210702	Дотоод албан томилолт	433,353,584.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,598,084,491.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,480,954,594.16
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,724,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	74,084,748.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,023,992.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,446,143.00
210807	Газрын төлбөр	8,571,814.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	14,213,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,054,495,735.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,638,792,127.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,415,703,608.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	965,140,450.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	965,140,450.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,888,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	956,252,450.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	10,407,626,133.47
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(10,407,626,133.47)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(10,407,626,133.47)

3. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны эрхэм зорилго нь соёлын өв, үндэсний уламжлалыг өвлөн уламжилсан, соёлын болон бие бялдрын боловсролтой өв тэгш монгол хүнийг төлөвшүүлж, залуучуудын үнэлэмжийн нэмэгдүүлэн, уламжлал, шинэчлэлийг хослуулан соёл, урлаг, спортын олон улсад өрсөлдөх нөхцөлийг сайжруулж, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар эх орноо хайрлах үзэл ухамсрыг төлөвшүүлэн түгээж, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийг хангахад оршино гэж тодорхойлсон байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь үйл ажиллагааны тэргүүлэх 5 чиглэл, эрхэм зорилгынхоо хүрээнд хэрэгжүүлэх стратегийн 8 зорилт тавьж, 128 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ.

ССАЖЗЯам нь бодлого, эрх зүй, төсөв санхүү, дижитал шилжилт, соёл урлаг, соёлын өв, биеийн тамир спорт, аялал жуулчлал, залуучууд, гадаад хамтын ажиллагаа, төрийн захиргаа хүний нөөцийн удирдлага болон хяналт шинжилгээ, дотоод аудитыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, Монгол Улсын үндэсний ижилсэл, бахархал, хөгжлийн чухал тулгуур хөгжлийг зөвхөн эдийн засгийн тоон үзүүлэлтээр бус соёлын дархлаа, спортын амжилт, залуучуудын оролцоо, аялал жуулчлалын өсөлтөөр хэмжих бодлогыг хэрэгжүүлж байна.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Аялал жуулчлалын тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Үндэсний их баяр наадмын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Соёлын бүтээлч үйлдвэрийг дэмжих тухай хууль, Номын сангийн тухай хууль, Музейн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хууль /нэмэлт өөрчлөлт оруулах тухай/;
- Соёлын тухай хууль /өөрчлөн найруулсан/;
- Үндэсний баяр наадмын тухай хуульд өөрчлөлт;
- Номын сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/;
- Биеийн тамир, спортын тухай хууль /шинэчилсэн найруулга/;
- Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар “Засгийн газрын агентлагийн бүтэц орон тооны талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тогтоол;

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Соёлын сайдын 2022 оны А/02 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг одоо мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 109,095.9 сая төгрөгөөр буюу 6.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
МӨНГӨН ХӨРӨНГӨ	27,002.9	5,012.9	(21,990.0)
АВЛАГА	8,771.6	13,246.8	4,475.2
УРЬДЧИЛГАА	8,541.6	6,560.4	(1,981.2)
БАРАА МАТЕРИАЛ	42,557.9	45,345.1	2,787.2
НӨӨЦИЙН БАРАА	552,354.5	560,100.7	7,746.2
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,000.0	1,000.0	-
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	921,107.8	1,040,888.8	119,781.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,561,336.1	1,672,539.6	111,203.5
НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,498.3	10,552.0	6,053.7
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,556,837.8	1,661,987.8	105,150.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,561,336.1	1,672,539.6	111,203.5

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө 19 хувь буурсан
- Авлага 51.0 хувиар өссөн;
- Өр төлбөр 34.5 хувь өссөн;
- Үндсэн хөрөнгө 13 хувиар өссөн;
- Урьдчилгаа 77 хувь буурсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,012.9 сая төгрөг болж, өмнөх оноос 22,036.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
----------	----------------	-----------------	--------------------------

Кассын бэлэн мөнгө	4.9	0.4	(4.5)
Төрийн сангийн харилцах	26,646.5	4,726.7	(21,919.8)
Арилжааны банк дахь харилцах	339.9	285.8	(54.1)
Бусад төсөл, нөөцийн харилцах	11.6	0	(11.6)
Нэмэлт санхүүжилтийн харилцах	46.2	0	(46.2)
Дүн	27,002.9	5,012.9	(22,036.2)

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нээлтээсний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нийт мөнгөн хөрөнгийн 82.4 хувь буюу 4,726.7 сая төгрөгийг төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл эзэлж байна. Үүнээс Барьцаа хөрөнгийн дансанд барилгын чанарын баталгааны барьцааны 2,511.5 сая төгрөг, Соёл урлагийн Хөрөнгө оруулалт 2,008.1 сая төгрөг, Захиалагчийн техник хяналтын 207.1 сая төгрөг байна.

Арилжааны банкны үлдэгдэлд Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв 1.5 сая төгрөг, Монгол кино нэгтгэл ТӨҮГ 284.3 сая төгрөгийн үлдэгдэл тус тус байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх тайлант оны эцэстэй харьцуулахад 22,036.2 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэл 25,853.7 сая төгрөгөөс 4,368.1 сая төгрөг болж, 21,485.6 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

-Төсөвт байгууллагын өөрийн орлогыг төсвийн дансанд төвлөрүүлээгүй 223.5 сая төгрөг байна. /Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театр 2.6 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны соёлын төв 3.4 сая төгрөг, Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн соёлын төв 2.5 сая төгрөг, Хөвсгөл аймгийн БТСГ 2.7 сая төгрөг, Өмнөговь аймаг БТСГ 49.9 сая төгрөг, Өвөрхангай аймгийн БТСГ 28.9 сая төгрөг, Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв 215.0 сая төгрөг, Дуурь бүжгийн эрдмийн театр 21.0 сая төгрөг, Дүрслэх урлагийн музей 31.9 сая төгрөг/;

-Албан хаагчдын цалин, урамшууллын тооцооллыг 4.4 сая төгрөгөөр зөрүүтэй тооцож олгосон. /Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн соёлын төв 0.2 сая төгрөг, Өмнөговь аймгийн Сэврэй сумын Соёлын төв 0.3 сая төгрөг, Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Соёлын төв 1.0 сая төгрөг, Мөнххаан сумын Соёлын төв 0.4 сая төгрөг, Сүхбаатар сум сумын Соёлын төв 0.3 сая төгрөг, Төв аймгийн Алтанбулаг сумын Соёлын төв 0.1 сая төгрөг, Лүн сумын Соёлын төв 0.8 сая төгрөг, Гурванбулаг сумын Соёлын төв 1.5 сая төгрөг, БТСУХ 40.9 сая төгрөг, Богд хааны ордон музей 0.4 сая төгрөг, Монголын Үндэсний музей 2.2 сая төгрөг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам 0.4 сая төгрөг, Соёлын өвийн үндэсний төв 3.3 сая төгрөг, Улсын төв номын сан 2.0 сая төгрөг, Хүүхэд залуучуудын театр 1.5 сая төгрөг, Чингис хаан музей 4.2 сая төгрөг/;

-Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримттай 554.8 сая төгрөгийн ажил гүйлгээг хийсэн. /Хэнтий аймгийн Дархан сумын Соёлын төв 6.7 сая төгрөг, Гурванбаян тосгоны соёлын төв 3.8 сая төгрөг, Төв аймгийн Эрдэнэ сумын Соёлын төв 1.4 сая төгрөг, Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газар 0.5 сая төгрөг, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Соёлын төв 23.0 сая төгрөг, Хүрмэн сумын Соёлын төв 1.7 сая төгрөг, БТСУХ 517.7 сая төгрөг/;

-Түлш халаалтын зардлаас албан хаагчдад түлээ, нүүрсний хөнгөлөлт 1.2 сая төгрөг олгосон. /Булган аймгийн Гурванбулаг сумын Соёлын төв 0.2 сая төгрөг, Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Соёлын төв 0.8 сая төгрөг, Хэнтий аймгийн Галшар сумын соёлын төв 0.2 сая төгрөг/;

Бараа үйлчилгээний бусад зардлаас ажлын зураг төсөв хийх, төмөр шүүгээ, тарьц мод, сэлбэг хэрэгсэл, мотор, хулдаас зэргийг худалдан авах, бүжгийн багш, дууны багшийн ажлын хөлс 23.3 сая төгрөг шилжүүлэхдээ гэрээ байгуулаагүй. /Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Соёлын төв 12.6 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Мандал сумын дуу бүжгийн чуулга 1.7 сая төгрөг, Төв аймгийн музей 9.0 сая төгрөг/;

-Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 47.7 сая төгрөгийн өргөмжлөл, хүүхдийн бэлэг, дугуйн уралдаанд зарцуулсан, тэмцээний шагналын зардал гаргасан. /Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Соёлын төв 2.5 сая төгрөг, Сүхбаатар аймгийн Халзан сумын Соёлын төв 0.3 сая төгрөг, БТСУХ 0.1 сая төгрөг, Баянхонгор аймгийн БТСГ 19.8 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн БТСГ 1.5 сая төгрөг, Багануур дүүргийн БТСГ 23.5 сая төгрөг /; Албан хаагчдад 2.1 сая төгрөгийн ажлын хувцас худалдан авсан / Төв аймгийн Цээл сумын Соёлын төв 0.9 сая төгрөг, БТСУХ 1.2 сая төгрөг/;

-Архангай аймгийн БТСГ "Бүсчилсэн хөгжлийн иргэдийн спортын их наадам" -ын төсөвт тусгагдаагүй шууд дамжуулал болон зар контентод 10.5 сая төгрөг;

-Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд байдаггүй 16 хүнд 65.6 сая төгрөгийг үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих зардлаас олгосон, "Биатлоны Үндэсний шигшээ багт тэмцээнд оролцох, бэлтгэлд хамрагдах зардал гаргах тухай" А/66 дугаар тушаалаар Дэлхийн цомын аварга

шалгаруулах олимпын эрхийн оноо олгох Европын цуврал тэмцээн, бэлтгэлд 1 тамирчин яваагүй, төсөв тусгагдсан улсын тэмцээнд оролцоогүйгээс 28.3 сая төгрөгийн төсөв хэмнэгдсэн байхад Биатлоны холбоо нь буцаан тушаагаагүй;

-БТСУХ нь олон жилийн хугацаанд өөрийн эзэмшлийн байрны 71.7 хувийг буюу 6238.3 м2 талбайг үнэ төлбөргүй хувь хүн, хуулийн этгээдэд ашиглуулж төсөвт орлого төвлөрүүлэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй мөн байр ашиглалт, харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээний зардалд нь 423.5 сая төгрөгийг төлсөн;

-БТСУХ нь өмнөх онуудад нас барсан 8 ахмадад 16.1 сая төгрөгийг олгосон;

Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн 36.9 сая төгрөгөөр зарцуулсан /Байгалийн түүхийн музей 2.6 сая төгрөг, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн 34.3 сая төгрөг.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 13,246.8 сая төгрөг болж өмнөх оноос 4,475.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+) Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	163.3	94.2	(69.1)
Төлбөртэй үйлчилгээний авлага	284.1	281.6	(2.5)
Татаас, санхүүжилтийн авлага	5,688.6	10,830.1	5,141.5
Дансны авлага /ТӨҮГ/	147.7	64.7	(83.0)
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	2.9	12.6	9.7
Байгууллагаас авах авлага	2,294.8	1,752.5	(542.3)
Хувь хүмүүсээс авах авлага	190.1	211.1	21.0
Дүн	8,771.5	13,246.8	4,475.3

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Авлага дансны үлдэгдэл 13,246.8 сая төгрөг болж өмнөх оноос 4,475.3 сая төгрөгөөр өсөхөд дараах хүчин зүйлүүд голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулах эрхийг хязгаарласантай холбоотойгоор байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлогоос санхүүжих зардлууд хойшилж, татаас, санхүүжилтийн авлага дансны үлдэгдлийг 9,823.7 сая төгрөг болгож, өмнөх оноос 4,135.1 сая төгрөгөөр өсөж голчлон нөлөөлсөн;
- Чингис хаан үндэсний музейн татаас, санхүүжилтийн авлага 5,367.6 сая төгрөг болж өмнөх оноос 932.2 сая төгрөгөөр, Улсын дуурь бүжгийн эрдмийн театр 968.1 сая төгрөгөөр, Үндэсний урлагийн их театр 926.1 сая төгрөг болж өмнөх оноос 856.1 сая төгрөгөөр, Үндэсний түүхийн музей 472.8 сая төгрөгөөр, Хүүхэд залуучуудын театр 443.3 сая төгрөг болж 392.9 сая төгрөгөөр, Богд хааны ордон музей 386.2 сая төгрөг болж 271.8 сая төгрөгөөр, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын харьяа байгууллагууд 823.7 сая төгрөг болж өмнөх оноос 539.1 сая төгрөгөөр, Биеийн тамир спортын улсын хорооны харьяа байгууллагууд 316.5 сая төгрөг болж 316.1 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

-Авлагын дансны үлдэгдлийг тооцоо нийлж тулган баталгаажуулаагүй. /Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музей 1.2 сая төгрөг, Дархан-Уул аймгийн залуучууд театр 4.0 сая төгрөг, Орхон аймгийн БТСГ 9.3 сая төгрөг, дуурь бүжгийн эрдмийн театр 176.2 сая төгрөг ;

-Тайлан оны санхүүгийн тайлант цалин, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой шинээр үүссэн авлагыг тусгаж тайлагнаагүй. /Ховд аймгийн Зэрэг сумын соёлын төв 0.1 сая төгрөг, Төв аймгийн Заамар сумын Соёлын төв 0.5 сая төгрөг, Төв аймгийн музей 9.0 сая төгрөг, Хөвсгөл аймгийн нийтийн номын сан 1.6 сая төгрөг/;

-Төсөв байгууллагын өөрийн орлого бүрдүүлэлтэд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сул байгаагаас тайлант онд авлага үүсгэсэн. /Төв аймгийн Борнуур сумын Соёлын төв 6.6 сая төгрөг, Булган аймгийн Рашаант сумын Соёлын төв 0.3 сая төгрөг/;

-Олон жил болсон насжилт өндөр, он дамжсан данс бүртгэлд тусгасан авлагыг барагдуулаагүй. /Тайшир сумын Соёлын төв 0.5 сая төгрөг, Жаргалант сумын Соёлын төв 0.2 сая төгрөг, Дархан-Уул аймгийн залуучууд театр 4.3 сая төгрөг/;
 -Удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтанд шүүхийн шийдвэрээр цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсвөөс төлсөн. /Ховд аймгийн хөгжимт драмын театр 6.0 сая төгрөг, Бигэр сумын Соёлын төв 2.4 сая төгрөг, БТСУХ 33.4 сая төгрөг/;
 -Баянхонгор аймгийн БТСГ халаалтын төсвийг төсөвлөснөөс 12.2 сая төгрөг илүү тооцон шилжүүлж авлагаар тусгаагүй;
 -Өмнөговь БТСГ нь он дамжсан 0.6 сая төгрөгийн авлага барагдуулаагүй.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс нь тайлант онд 6,560.4 болж өмнөх оноос 1,981.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	8,375.0	6,558.4	(1,816.6)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	12.3	0.0	(12.3)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.0	2.0	2.0
Цалингийн урьдчилгаа	0.2	0.0	(0.2)
Томилолтын урьдчилгаа	154.0	0.0	(154.0)
Дүн	8,541.5	6,560.4	(1,981.1)

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Урьдчилж гарсан зардал данс нь тайлант онд 6,560.4 болж өмнөх оноос 1,981.1 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: Биеийн тамир, спортын улсын хорооны 2,988.6 сая төгрөг, Соёлын яамны хөтөлбөр, арга хэмжээний дансны 2,730.4 сая төгрөг, Чингис хааны өв соёлын хүрээлэн 341.0 сая төгрөг, Улсын хүүхэлдэйн театрын 316.4 сая төгрөг, Кино урлагийг дэмжих сангийн 56.0 сая төгрөг, Богд хааны ордон музей 37.4 сая төгрөг, Дүрслэх урлагийн музейн 30.5 сая төгрөг, нийслэлийн соёл, урлаг, аялал жуулчлалын газар 27.0 сая төгрөг, Улсын дуурь бүжгийн эрдмийн театр 23.4 сая төгрөг, Байгалийн шинжлэх ухааны үндэсний музейн ашиглалтын өмнөх захиргаа 3.6 сая төгрөг, Театрын музей 1.5 сая төгрөг, Орон нутгийн байгууллагууд 4.6 сая төгрөгийн үлдэгдэл тус тус багтсан байна.

Аудитын илрүүлэлт:

-ССАЖЗЯ-ны хөтөлбөр арга хэмжээний тайланд 2022 онд “Урьдчилж төлсөн зардал” дансанд Ай Ти Зон ХХК-тай 294.4 сая, И Эс Эй Эн ХХК-тай 225.0 сая төгрөгийн гэрээ байгуулж төлбөрийг бүрэн шилжүүлсэн боловч гэрээний хугацаа дууссан, ажил, үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн эсэх нь тодорхойгүй, гүйцэтгэлийг нотлох акт баримт бүрдээгүй бөгөөд холбогдох арга хэмжээг тайлант онуудад авч хэрэгжүүлээгүй байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 45,345.1 сая төгрөг болж өмнөх оноос 2,787.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	10,847.0	11,998.7	1,151.7
Хангамжийн материал	31,710.9	33,346.4	1,635.5
Дүн	42,557.9	45,345.1	2,787.2

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны эцэст нийт бараа материал 45,345.1 сая төгрөг бөгөөд Булган аймгийн номын сан, Хүүхэд залуучуудын театр, Үндэсний номын сангийн шинээр ашиглалтад орж байгаагаас

шалтгаалан өмнөх оноос нийтдээ 12,055.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нөөцийн бараанд Чингис хаан музейн хуулбар уран зургууд болон Дорнод аймгийн Булган сумын барилгын засварын материал тусгасан байна.

Аудитын илрүүлэлт:

-Нийслэлийн Соёл урлагийн газар нь Нийслэлийн засаг даргын тамгын газраас Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах зардлаас гарсан 585.1 сая төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан боловч байгууллагад биетээрээ ирээгүй, бараа материал хүлээлцсэн акт үйлдээгүй, 177.1 сая төгрөгийн бараа материалын тайланг материалын нэр төрөл, тоо хэмжээгээр нэгтгэн гаргадаггүй, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлэлгүй 1.0 сая төгрөгийн түлээ нүүрсийг худалдан авч нөөцөлсөн;

-Материалын тайланд жилийн эцсийн тооллогыг үнэн зөв, чанартай хийгээгүй. /Булган аймгийн Хишиг-Өндөр сумын Соёлын төв 1.9 сая төгрөг, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Соёлын төв 6.8 сая төгрөг, Ховд аймгийн Мөст сумын соёлын төв 7.2 сая төгрөг/;

Бараа материалын тайланд орлого, зарлагын баримт, шаардах хуудас дутуу хөтөлсөн. /Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Соёлын төв 4.4 сая төгрөг, Гучин-Ус сумын Соёлын төв, Хайрхан дулаан сумын Соёлын төв/;

-Шатахууны замын хуудас бөглөөгүй, тооцоо хийгээгүй. /Төв аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлалын газар 3.2 сая төгрөг, Эрдэнэ сумын Соёлын төв 0.4 сая төгрөг, Дархан-Уул аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар 2.0 сая төгрөг, Орхон аймгийн соёл урлагийн газар, Орхон аймгийн хүүхэд залуучуудын театр 1.2 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар 2.5 сая төгрөг/;

-Соёлын төвийн өрөө тасалгааг засуулахаар гэрээ байгуулан санхүүжилт, бараа материалыг нь олгосон боловч тайлант ондоо багтааж засварын ажлаа хийж, хүлээлгэж өгөөгүй. /Төв аймгийн Дэлгэрхаан сумын Соёлын төв 4.0 сая төгрөг, Ховд аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар/;

-Баян-Өлгий аймгийн Булган сумын соёлын төвийн бараа материалын тайлан дахь эхний үлдэгдэл, нярвын хөрөнгийн тайлангийн эхний үлдэгдэл 1.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;

-Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн шатахууны тайланд биетээр байхгүй 2.3 сая төгрөгийн шатахуун бүртгэлтэй;

-Булган аймгийн Тэшиг сумын Соёлын төвийн аж ахуйн материал дансанд 3.0 сая төгрөгийн үнэтэй соёлын өв болох тоглолтын 6 нэр төрлийн хувцас материал хэлбэрээр бүртгэлтэй;

-Төв аймгийн Сүмбэр сумын Соёлын төв номын сангийн уншлагын танхимд 0.9 сая төгрөгийн 4 ширхэг хөшгийг нийлүүлэгчийн нэр, мөнгөн дүн зөрүүтэй орлогод авч буцаан зарлагадсан;

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн соёлын төвийн аж ахуйн материал дансанд 105 нэр төрлийн 27.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгө байна;

Говьсүмбэр аймгийн БТСГ нь аж ахуйн материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 2.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн;

-Тээвэр шатахууны зардлыг жолоочийн тооцооны хуудас, анхан шатны баримтгүй, эм боох материалыг эмчилгээний хуудасгүй зарцуулсан нийт 9.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн./ БТСУХ 7.5 сая төгрөг, Хөвсгөл аймгийн БТСГ 0.5 сая төгрөг, САУЭШТ 0.6 сая төгрөг,САУЭШТ 1.1 сая төгрөг/;

-БТСУХ нь бараа материалыг нэг бүрийн үнэ, тоо хэмжээ, нэр төрлийг тусгаагүй, бөөн дүнгээр орлого авч зардалд бүртгэдэг, тараалтын хуудасгүй, зарцуулалтыг нотлох баримтгүй, тооцооны дансаар дамжуулдаггүй нийт 316.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн;

-Хөвсгөл аймгийн БТСГ-ын бараа материалын дансанд биетээр байхгүй, тухайн цаг хугацаандаа зарлагадаагүй үлдэгдэлд бүртгэлтэй эд зүйлсийг 42.2 сая төгрөгийн эд зүйлсийг өмч хамгаалах комисс, удирдлагын тушаал шийдвэргүй зардалд тайлагнасан.

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 560,100.7 сая төгрөг болж өмнөх оноос 8,115.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	551,984.9	560,100.7	8,115.8
Дүн	551,984.9	560,100.7	8,115.8

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бусад эргэлтийн хөрөнгө дансанд Биеийн тамир спортын улсын хорооны дуусаагүй барилгын үлдэгдэл 6,347.1 сая төгрөг болон хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 553,753.5 сая төгрөг багтсан.

Аудитын илрүүлэлт:

-Бусад эргэлтийн хөрөнгө дансанд 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 1,030.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулж, салбарын соёлын байгууллагуудад хуваарилаагүй. /Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хөрөнгө оруулалт их засвар 1,030.9 сая төгрөг/;

-Бусад эргэлтийн хөрөнгө дансанд хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийг үе шат бүрээр бүртгээгүй, 2 буюу түүнээс дээш жил болсон, хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөөтэй эсэх нь тодорхой бус нийт 347,041.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. /Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хөрөнгө оруулалт их засвар 347,041.1 сая төгрөг/.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,040,888.9 сая төгрөг болж өмнөх оноос 119,781.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	878,535.1	991,778.2	113,243.1
Барилга, байгууламж, орон сууц	713,512.4	828,264.7	114,752.3
Авто-тээврийн хэрэгсэл	8,409.5	8,991.8	582.3
Машин тоног төхөөрөмж(компьютер)	105,303.3	117,430.5	12,127.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	48,802.9	54,321.9	5,519.0
Зам, гүүрний байгууламж	4,274.9	5,024.1	749.2
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	125,669.0	125,405.8	(263.2)
Бусад үндсэн хөрөнгө	23,717.6	37,325.8	13,608.2
Дуусаагүй барилга, байгууламж	5,260.3	4,388.9	(871.4)
Ном	11,138.4	11,467.5	329.1
Биет бус хөрөнгө	42,572.7	49,148.4	6,575.7
Программ хангамж	2,122.7	2,189.2	66.5
Бусад биет бус хөрөнгө	41,594.4	49,148.4	7,554.0
Дүн	921,107.8	1,040,888.9	119,781.1

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Салбарын нийт хөрөнгө өмнөх оноос 119,781.1 сая төгрөгийн өсөлтөд барилга байгууламж, орон сууц 114,752.2 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө 13,608.2 сая төгрөг, машин тоног төхөөрөмж (компьютер) 12,127.2 сая төгрөг тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Тухайлбал: Чингис хаан музей 101,057.2 сая төгрөг, Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв 46,083.2 сая төгрөг, Үндэсний номын сан 34,673.1 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

-Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгүүдийн үнэ болон ашиглах хугацааг шинэчлэн тогтоолгоогүй. /Нийслэлийн Соёл урлагийн газар 243.3 сая төгрөг, Булган аймгийн хөгжимт жүжгийн театр 413.9 сая төгрөг, Хангал сумын Соёлын төв 41.9 сая, төгрөг Булган сумын Соёлын ордон 69.6 сая төгрөг, Завхан аймгийн Цэцэн-Уул сумын Соёлын төв 76.1 сая төгрөг, Цагаанхайрхан сумын Соёлын төв 78.8 сая төгрөг, Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Соёлын төв 17.6 сая төгрөг, Төв аймгийн Бүрэн сумын Соёлын төв 1.9 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Хушаат сумын Соёлын төв 9.7 сая төгрөг, СХД БТСХ-д 4 төрлийн 138.6 сая төгрөг, ХУД БТСХ-д 4 төрлийн 94.5 сая төгрөг, Багахангай дүүргийн БТСХ-д 3 төрлийн 28.8 сая төгрөг, БЗД БТСХ-д 52 нэр төрлийн 52.4 сая төгрөг, Баянхонгор аймгийн БТСГ-т 72 нэр төрлийн 203 ширхэг 85.2 сая төгрөг, БТСУХ-д 3,156 ширхэг 2,504.8 сая төгрөг, Өмнөговь аймгийн БТСГ-т 44 ширхэг үлдэх өртөггүй машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, Хөвсгөл аймгийн БТСГ-т 65 нэр төрлийн 80 ширхэг 53.9 сая төгрөг/;

-Үндсэн хөрөнгийн түүвэр тооллогоор бөөн дүнгээр бүртгэсэн. /Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Соёлын төв 10.6 сая төгрөг, Цогтцэций сумын Соёлын төв 1.9 сая төгрөг/;

-Жилийн эцсийн тооллого хийгээгүй. /Булган аймгийн Дашинчилэн сумын Соёлын төв 697.8 сая төгрөг, Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Соёлын төв 30.5 сая төгрөг, Ховд аймгийн Цэцэг сумын соёлын төв 14.3 сая төгрөг, Чандмань сумын соёлын төв 9.8 сая төгрөг, Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Соёлын төв 2.3 сая төгрөг, Нийслэлийн Соёл урлагийн газар, Өмнөговь аймгийн Номгон сумын Соёлын төв, Мандал-Овоо сумын Соёлын төв, Ноён сумын Соёлын төв, Ханхонгор сумын Соёлын төв./;

-Өвөрхангай аймгийн төв номын сан эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр 68.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг тогтоож, ашиглалтын хугацааг сунгасан;

-Архангай аймгийн Өлзийт сумын Соёлын төвийн үндсэн хөрөнгийг ангиллын дагуу бүртгэсэн эсэхийг хянаж үзэхэд тавилга эд хогшлын дансанд хамааралгүй 21.6 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 0.3 сая төгрөгийн бараа материалыг буруу бүртгэсэн;

-Ховд аймгийн хөгжимт драмын театр жүжгийн зохиол, хөгжмийн зохиол, найруулга, бүжиг дэглэлт, хоолойн бичлэг зэрэг хөлсөөр хийгдэж байгаа биет бус хөрөнгийн шинж чанартай зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэх талаар НББББ-т тодорхой заагаагүйгээс 16.5 сая төгрөгийг шууд зардалд бүртгэж тайлагнасан;

-Ховд аймгийн Алтай сумын соёлын төв үндсэн хөрөнгө орлого авахдаа санхүүгийн программд ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 3 нэр төрлийн 5.9 сая төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй байна;

-БТСУХ нь спортын холбоодод 872.9 сая төгрөгийн 958 ширхэг бараа материал, 1,672.3 сая төгрөгийн 698 ширхэг үндсэн хөрөнгийг өгч ашиглуулдаг боловч эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх гэрээ байхгүй, коджуулалт хийгээгүй, Биеийн тамир, спортын цахим мэдээллийн сангийн 236.7 сая төгрөгийн программ хангамжийг 2020 онд тендер шалгаруулалтаар хийлгэсэн боловч биет бус хөрөнгөд бүртгээгүй;

-Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баталгаажуулаагүй. /Дундговь, Архангай аймгийн БТСГ, Байгалийн түүхийн музей 0.3 сая төгрөг, Дүрслэх урлагийн музей 83.7 сая төгрөг, Театрын музей 8.2 сая төгрөг/.

Программ хангамжийн бүртгэл: Сайдын багцын хүрээнд нийт 2,189.2 сая төгрөгийн программ хангамж бүртгэлтэй байгаагийн 622.6 сая төгрөгийг Үндэсний номын сангийн "Коһа" номын сангийн систем, Соёлын өвийн төвийн Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем 124.1 сая төгрөг, Биеийн тамир, спортын улсын хорооны харьяа байгууллагуудын 429,6 сая төгрөг, Соёл, урлагийн газрын харьяа байгууллагуудын 755.2 сая төгрөгийн программ хангамж тус тус багтсан байна. Биет бус хөрөнгөд бүртгэлтэй ашиглахгүй байгаа программ хангамжуудыг данс бүртгэлээс хасаагүй 0.9 сая төгрөг, данс бүртгэлд бүртгэлгүй 236.7 сая төгрөгийн 3 программ хангамж байна.

3.4.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 10,551.8 сая төгрөг болж өмнөх оноос 6,053.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Арилжааны банк	40.4	0.0	(40.4)
Ажилчидтай холбогдсон өглөг	309.8	471.6	161.8
Бараа үйлчилгээний зардлын өглөг	164.1	564.7	400.6
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	1.1	1.1	0.0
Бусад өглөг	3,982.9	9,483.3	5,500.4
Урьдчилж орсон орлого	0.0	10.8	10.8
Дүн	4,498.3	10,551.8	6,053.5

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Өмнөх оноос өр төлбөр дансны үлдэгдэл нь урсгал санхүүжилтийн эрх, нэмэлт санхүүжилтийн зарцуулах эрхийг хязгаарласнаас шалтгаалан нийтлэг өссөн бөгөөд Хөтөлбөр, арга хэмжээний дансны өр төлбөр 2,837.3 сая төгрөг болж 2,834.9 сая төгрөгөөр, Соёл урлагийн газрын төсвийн төвлөрүүлэн захирагч 1,165.6 сая төгрөг болж 715.9 сая төгрөгөөр, Хөрөнгө оруулалтын данс 1,921.9 сая төгрөг болж 511.0 сая төгрөгөөр, Биеийн тамирын улсын хорооны төсвийн төвлөрүүлэн захирагч 503.6 сая төгрөг болж 232.8 сая төгрөгөөр, Чойжин ламын сүм музей 125.8 сая төгрөг болж 115.8 сая төгрөгөөр, Чингис хаан

үндэсний музей 1,606.7 сая төгрөгөөр, Хүүхдийн төв номын сан 132.8 сая төгрөгөөр, Улсын хүүхэлдэйн театр 110.6 сая төгрөгөөр тус тус өссөн зэрэг нь голчлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

-Өр төлбөр дансны үлдэгдлийг тооцоо нийлж тулган баталгаажуулаагүй. /Дархан-Уул аймгийн залуучууд театр 27.7 сая төгрөг, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Соёлын төв 3.4 сая төгрөг, Ховд аймгийн Булган сумын соёлын төв 1.6 сая төгрөг, Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв 0.3 сая төгрөг, Төв аймгийн БТСГ 3.7 сая төгрөг, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн 2.9 сая төгрөг/;

-Төсөв байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сул байгаагаас тайлант онд шинээр өглөг үүссэн. /Алаг-Эрдэнэ сумын Соёлын төв 2.3 сая төгрөг, Булган аймгийн төв номын сан 3.4 сая төгрөг, Хялганат сумын Соёлын төв 2.2 сая төгрөг, Төв аймаг Монгол туургатан театр 48.8 сая төгрөг, Төв аймгийн Борнуур сумын Соёлын төв 0.7 сая төгрөг/;

-Олон жил болсон насжилт өндөр, он дамжсан данс бүртгэлд тусгасан өр төлбөрийг барагдуулаагүй. /Соёл урлагийн газар 1.9 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн Булган сумын соёлын төв 1.4 сая төгрөг/.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,672,539.6 сая төгрөг болж өмнөх оноос 111,172.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын хувь оролцоо	1,556,866.4	1,661,987.9	105,121.5
Засгийн газрын оруулсан капитал	209,028.8	215,208.7	6,179.9
Улсын төсвийн оруулсан хөрөнгө	103,006.3	114,151.1	11,144.8
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	106,022.5	101,057.6	(4,964.9)
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	31,518.1	31,518.1	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	1,012.4	1,012.4	-
Хуримтлагдсан үр дүн	1,077,426.4	1,178,638.3	101,211.9
Өмнөх үеийн үр дүн	702,273.5	1,075,211.0	372,937.5
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,561,367.0	1,672,539.6	111,172.6

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 111,172.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр 102,84.8 сая төгрөг голчлон нөлөөлж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,051,885.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төсөлд өгсөн саналаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 75,910.6 сая төгрөгөөр бууруулж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал 35,836.2 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4,615.9 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2,242.3 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 1,086.4 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 2,638.2 сая төгрөг, томилолт зочны зардал 774.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 69,501.2 сая төгрөг, урсгал шилжүүлэг 4,486.1 сая төгрөг, нийт 526,533.5 сая төгрөгийн зардлыг бууруулж, 525,351.8 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн өөрчлөлтөөр анх батлагдсан 525,351.8 сая төгрөгөөс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 19,910.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал 6,484.2 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл

256.3 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 843.5 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 175.3 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 24.2 сая төгрөг, томилолт зочны зардал 46.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 11,143.2 сая төгрөг, урсгал шилжүүлэг 4,972.5 сая төгрөг, нийт 84,484.7 сая төгрөгийн зардлыг бууруулж, 440,866.4 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 59 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 440,866.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, гүйцэтгэлээр 391,545.1 сая төгрөгийн санхүүжилт авч, 384,098.8 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй 7,446.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 384,098.8 сая төгрөг буюу 85.9 хувьтай байгаа нь хөрөнгийн зардал 30,306.4 сая, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 6,053.2 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,580.9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 13,147.7 сая төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

3.5.3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71411 - Хүрээлэн буй орчны бодлого						
1	80918	Бусад	596.3	596.3	0.0	100
Дүн			596.3	596.3	0.0	100
71701 - Биеийн тамир спорт						
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,245.8	1,217.6	28.2	97.7
2	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	45.6	45.1	0.6	98.7
3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	0.5	0.5	-	100
4	80918	Бусад	32,949.4	19,942.3	13,007.1	60.5
5	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	5.9	5.9	0.0	100
6	82105	Олимп ДАШТ-с медаль авсан тамирчдад олгох	2,129.8	1,945.2	184.6	91.3
7	82109	Допинг эсрэг ү/ажиллагааг дэмж	590.0	590.0	-	100
8	82112	Олимп, паралимпийг дэмжих үйл ажиллагаа	808.8	578.5	230.3	71.5
9	82115	Идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих	1,050.6	873.0	177.6	83.1
10	82116	Үндэсний тэмцээн, наадмын үйл ажиллагаа	2,415.8	2,058.5	357.2	85.2
11	82117	Бусад спортыг дэмжих	854.8	797.9	56.8	93.3
12	82118	Үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих	12,313.9	11,619.5	694.4	94.4
13	82119	Дотоодод зохиогдох олон улсын тэмцээн	2,913.9	2,850.3	63.6	97.8
14	82120	Спортын өндөр амжилтын шагнал, урамшуулал	2,648.0	1,340.7	1,307.3	50.6
Дүн			59,972.7	43,864.9	16,107.8	73.1
71702 - Соёл урлаг						
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	40,617.8	37,257.7	3,360.1	91.7
2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	518.4	518.2	0.1	100
3	80214	Уран бүтээл хийлгэх	357.2	357.1	0.1	100
4	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	1.6	1.6	-	100
5	80219	Харуул, хамгаалалтын зардал	111.1	91.4	19.7	82.2
6	80404	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	379.1	246.4	132.7	65.0
7	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	4,991.3	4,476.3	515.0	89.7
8	80918	Бусад	92,018.8	74,719.5	17,299.3	81.2
9	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	341.3	321.4	19.9	94.2
10	81855	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	6,663.5	5,583.3	1,080.2	83.8
11	81919	Оны шилдэг уран бүтээлч найруулагч шалгаруулах	75.0	75.0	-	100
12	81922	Гадаад дотоодод зохиогдох соёл	1,313.8	1,078.0	235.8	82.1
13	81930	Кино урлагийг дэмжих	500.0	224.0	276.0	44.8
14	81936	Цахим соёл хөтөлбөр	200.0	102.5	97.5	51.3

15	81947	Монгол Улсын Олон улс дахь сурталчилгаа, мэдээллийн үндэсний хорооны үйл ажиллагааны хэрэгжилт	193.0	193.0	0.0	100
16	81948	Театр, чуулгад гүйцэтгэлээр олгох санхүүжилт	45,631.7	45,343.6	288.2	99.4
17	81949	Номын санд гүйцэтгэлээр олгох санхүүжилт	10,120.2	9,819.9	300.3	97.0
18	81951	Соёлын төвд гүйцэтгэлээр олгох санхүүжилт	70,184.3	69,052.3	1,132.0	98.4
19	82801	Улсын их баяр наадам	1,500.0	1,497.3	2.7	99.8
Дүн			275,718.2	250,958.4	24,759.8	91.0
71703 - Аялал жуулчлал						
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	6,244.4	2,090.3	4,154.1	33.5
2	80404	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,221.9	736.9	485.0	60.3
3	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	2,003.0	1,699.0	304.0	84.8
Дүн			9,469.3	4,526.2	4,943.1	47.8
71704 - Соёл урлаг, спорт, бодлого, удирдлага						
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	49,238.2	44,787.3	4,450.8	91.0
2	80219	Харуул, хамгаалалтын зардал	76.3	69.3	7.0	90.9
3	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	669.8	551.9	117.9	82.4
4	80239	Тээврийн үйлчилгээ	100.0	75.0	25.0	75.0
5	80509	ОУ-ын байгууллагын гишүүнчлэл хураамж	140.1	130.7	9.4	93.3
6	80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмадад олгох	1,340.6	1,301.8	38.8	97.1
7	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	2,826.5	988.6	1,837.9	35.0
8	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	3,083.4	1,198.7	1,884.6	38.9
Дүн			57,474.8	49,103.3	8,371.5	85.4
71706 - Соёлын өв						
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	19,337.5	18,617.6	719.9	96.3
2	80214	Уран бүтээл хийлгэх	3.2	3.1	0.0	99.0
3	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	25.4	25.4	0.0	100
4	80219	Харуул, хамгаалалтын зардал	271.5	238.8	32.7	88.0
5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	363.8	326.1	37.6	89.7
6	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	569.9	488.2	81.7	85.7
7	81855	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	1,280.0	773.1	506.9	60.4
8	81908	Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	241.2	230.9	10.3	95.7
9	81922	Гадаад дотоодод зохиогдох соёл урлагийн арга хэмжээ	350.0	0.0	350.0	0.0
10	81938	Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд төрөөс үзүүлэх дэмжлэг	135.6	81.9	53.7	60.4
11	81950	Музейд гүйцэтгэлээр олгох санхүүжилт	11,083.3	10,764.0	319.3	97.1
12	81952	Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулах	3,000.0	2,917.5	82.5	97.3
Дүн			36,661.4	34,466.7	2,194.7	94.0
71707 - Соёлын бүтээлч үйлдвэрлэл						
1	81901	Соёл урлаг хөгжүүлэх	30.0	30.0	-	100
Дүн			30.0	30.0	-	100
72209 - Залуучууд болон оюутнууд						
1	83115	Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр	943.8	553.0	390.8	58.6
Дүн			943.8	553.0	390.8	58.6
Нийт дүн			440,866.4	384,098.8	56,767.6	85.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6. Судалгаа

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

Бүтэц орон тоо: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нийт 488 байгууллагын 8,002 орон тоонд 221,382.0 сая төгрөгийн цалин хөлс, нийгмийн даатгалын зардал батлагдаж, 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн төсвийн тодотголоор 9 хувийн цомхотгол хийх чиглэлтэйгээр 776 сул орон тоог царцааж, 488 байгууллагын 7,226 орон тооны 210,737.9 сая төгрөгийн зардлыг тодотгон баталсан. Жилийн эцсийн байдлаар

гүйцэтгэлээр 7,138 орон тоонд 203,645.7 сая төгрөгийн цалингийн зардалд зарцуулсан байна.

Унаа, хоолны хөнгөлөлт: Тайлан оны Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад хамаарах байгууллагуудын унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын нийт гүйцэтгэл 19,129.2 сая төгрөг, нэг өдрийн унаа, хоолны зардлын дүн хамгийн өндөр Үндэсний номын сан 51,500.0 төгрөгөөр тооцож олгодог, орон нутгийн соёлын харьяа байгууллагууд албан хаагчдад журмын дагуу хоол, унааны хөнгөлөлт олгодог боловч хоолны хөнгөлөлт 4,000-30,000 төгрөг, унааны хөнгөлөлт 400-3,000 төгрөгөөр тус тус ялгаатай олгож байна бөгөөд сумын соёлын төвийн байгууллагууд унаа хоолны мөнгийг огт олгодоггүй байна. Салбарын хэмжээнд нийт 7,136 албан хаагчаас 4,643 албан хаагчид унаа, хоолны мөнгө тооцон олгож 2,493 албан хаагчид олгоогүй байна.

Шүүхийн шийдвэрээр төрд учруулсан хохирол: Тайлант онд судалгаагаар ССАЖЗЯ-ны 2 албан хаагчийн 50.5 сая төгрөг, БТСУХ-ны 2 албан хаагчийн 32.3 сая төгрөг, Дуурь бүжгийн эрдмийн театр 1 албан хаагчийн 14.1 сая төгрөг, Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театр нь 2 албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалин хөлсний олговор 42.2 сая төгрөг, Дундговь аймгийн Төв номын сангийн 1 албан хаагчид 5.3 сая төгрөг, Говь-алтай аймгийн Чуулгын 2 албан хаагчид 44.5 сая төгрөг, Жангар номын сангийн 1 албан хаагчид 2.2 сая төгрөг, Бигэр сумын Соёлын төвийн 1 албан хаагчид 4.3 сая төгрөг, нийт 12 албан хаагч 195.9 сая төгрөгийн шүүхийн нэхэмжлэлтэй байна. Тайлант онд Говь-алтай аймгийн Бигэр сумын Соёлын төвийн 1.8 сая төгрөг барагдуулж, тухайн байгууллагын төсвөөс Говь -Алтай аймгийн Чуулга, Жангар номын сан нь 46.7 сая төгрөгийг олгож, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, Дундговь аймгийн Төв номын сан нь 5.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн, Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театр нь 42.2 сая төгрөгийг барагдуулаагүй байна.

Гадаад албан томилолт: Тайлант онд гадаад томилолтын зардал 62.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарснаас Чингис хаан үндэсний музейн Унгарын угсаатны зүйн музейтэй эрдэм шинжилгээний болон мэргэжлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, ОХУ-ын Санкт-Петербург хотод Монголчуудын өв соёл олон улсын эрдэм шинжилгээний VII хурлыг зохион байгуулах, Интермузей олон улсын фестивальд илтгэл тавих ажлуудаар музейн захирал болон эрдэм шинжилгээний албан хаагчид гадаад томилолтоор ажилласан 56.3 сая төгрөг, ССАЖЗЯ-ны “Монгол Улс – Цаг хугацааны аялал” үзэсгэлэнгийн бэлтгэл ажилд оролцох зорилготой Швейцарын Холбооны улсын Цюрих хотод зорчсон 5.7 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Хөтөлбөр, арга хэмжээний данснаас МУ-ын Ерөнхийлөгчийн БНЧех улс, БНПольш улс, БНИтали улсуудад хийсэн 2 удаагийн төрийн өндөр айлчлалын хүрээнд "Монголын сайхан орон" тоглолт, үзэсгэлэн зохион байгуулахад нийт 686.5 сая төгрөгийг зарцуулсан байна..

Тайлант онд 20 байгууллага бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг бараа үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас эдийн засгийн ангилал зөрүүлж 419.6 сая төгрөгийг зарцуулсан, Дүрслэх урлагийн музей 20.5 сая төгрөгийг тушаал шийдвэргүй, батлагдсан төсөвт тусгагдаагүй гадаад томилолтын зардалд зарцуулсанд албан шаардлага, Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад оронд хийсэн айлчлалын хүрээнд зохион байгуулсан урлагийн тоглолтын тайз засалт, түрээсийн зардал нийт 87.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Үндэсний урлагийн их театрын захирлын тушаалаар нэр бүхий 140 хүнийг томилолтоор ажиллуулахаар баталснаас театрын ажилтан биш 9 хүнд 4.7 сая төгрөгийн зардал гаргасанд зөвлөмж өгсөн.

Хэвлэл мэдээлэл: Тайлант онд 34 байгууллага бараа үйлчилгээний бусад зардал, нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж эдийн засгийн ангиллаас 710.9 сая төгрөгийн хэвлэл мэдээллийн ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээ байгуулж, 619.0 сая төгрөгийн гүйцэтгэл гаргасан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 4 хөтөлбөр, 19 хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн зорилтот түвшнийг тусгажээ.

Хүснэгт 11. Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

71702 Соёл урлаг	Хүрэх түвшин	2025 оны статистик үзүүлэлт	Тайлбар
Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж	50	38.7	2010 оны 88 дугаар тогтоолын аргачлалын дагуу 2025 онд мэргэжлийн урлагийн байгууллагын 3,676 тоглолтод нийт 1,425,359 хүн хамрагдсан нь нэг тоглолтод дунджаар ойролцоогоор 388 үзэгч, харин 2024 оны дундаж хүн ам (3,419,193)-д харьцуулахад нэг хүнд жилд 0.42 удаагийн тоглолт үзсэн хүртээмжтэй байна.
1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудал	35	36.5	2010 оны 88 дугаар тогтоолын аргачлалын дагуу 2024 оны дундаж хүн ам (3,419,193)-д харьцуулбал соёл, урлагийн байгууллагын нийт 124,844 суудал нь 1,000 хүнд дунджаар ойролцоогоор 36.5 суудал ногдож байна.
Технологийн бүтээгдэхүүн, хөгжүүлэлтэд оруулсан төсөл	15	10	
Нийтийн эзэмшлийн талбайд соёлын зориулалттай задгай талбайн хэмжээ	1,000	800	Нийслэлийн Баянзүрх дүүрэгт, Монгол Кино Нэгтгэл ТӨҮГ-ийн хамтран хэрэгжүүлсэн “Кино гудамж” төслийн талбай 800 м.кв.
71701 Биеийн тамир, спорт			
Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс авсан медаль	16	23	Жүдо бөхийн ДАШТ-ээс 2 хүрэл, чөлөөт бөхийн ДАШТ-ээс 1 мөнгө, 3 хүрэл, боксын ДАШТ-ээс 1 мөнгө, 1 хүрэл, 3x3 сагсан бөмбөгийн ДАШТ-ээс эмэгтэй баг мөнгөн медаль, пара жүдо бөхийн ДАШТ-ээс 2 хүрэл, пара байт харвааны ДАШТ-ээс 2 алтан медаль, пара пауэрлифтингийн ДАШТ-ээс 1 мөнгө, нийт 14 медаль хүртсэн.
Тивийн аварга шалгаруулах тэмцээн /тивийн наадам/-ээс авсан медаль	32	139	2025 онд Монгол Улсын шигшээ баг Харбин-2025 Азийн өвлийн наадам болон Турины Тусгай олимпын өвлийн дэлхийн наадамд амжилттай оролцож (Тусгай олимпоос 5 алт, 10 мөнгө, 6 хүрэл), мөн Ази, тив, дэлхийн зэрэглэлийн олон улсын тэмцээнүүдээс нийт 118 медаль хүртсэн байна.
6-64 насны бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдаж А, В, С үнэлгээ авсан хүний эзлэх хувь	69	70.7	2025 оны жилийн эцсийн байдлаар хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилд 142,226 иргэн (үүний 50.2% нь эмэгтэй) хамрагдсанаас А-С үнэлгээтэй 100,689 хүн буюу 70.7%-ийг эзэлж байна.
71703 Аялал жуулчлал			
Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалтад хамрагдах хүн	15,000	9000	2025 онд бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөн болон жуулчны үйлчилгээтэй холбоотой (жолооч, хөтөч, Харвард менежмент, зочлох үйлчилгээ, баазын технологи зэрэг) олон төрлийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 750 иргэн, 900 аж ахуйн нэгжийн нийт 9,000 албан хаагчийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан байна.
Монгол Улсыг сонирхсон гадаадын жуулчны цахим хандалт /нэмэгдэлтийн хувь/	30	20	2025 онд “Go Mongolia” брэндийн гадаад сурталчилгаа дэлхий даяар 432 сая гаруй хүнд хүрч, мөн БНСУ, Японы 17 инфлюенсерийн TikTok контент 41–102 сая лайк/хандалт авч гадаадын жуулчдын цахим хандалтыг мэдэгдэхүйц нэмэгдүүлсэн байна.
Гадаад, дотоодод зохион байгуулах арга хэмжээ	83	30	Тайлант жилд дотоодын 30 арга хэмжээг хувийн хэвшлийн төлөөлөл Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо болон бусад холбоодтой хамтран зохион байгуулсан.

72209 Залуучууд			
Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын нийт залуучуудад эзлэх хувь	30	30.8	2025 оны жилийн эцсийн байдлаар Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын тоо - 312,483 байна.
71704 Соёл, урлаг, спорт, аялал жуулчлалын бодлого, удирдлага			
Соёлын салбарын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	100	86	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 86% байна.
Биеийн тамир, спортын салбарын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	90	91	Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 91% байна.
71706 Соёлын өв			
Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлсэн дурсгалт газар	2	1	2025 онд "Хүннүгийн язгууртны оршуулгын цогцолбор дурсгалууд" өвийг нэр дэвшүүлсэн.
Шинээр нэмж бүртгэгдсэн өвлөн уламжлагч	10	176	2025 онд соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 176 хүнийг Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэсэн. 140 хүн нас барсан. 182 хүн шилжилт хөдөлгөөн хийж, бүртгэлээс хасагдсан.
Сэргээн засварласан дурсгалт зүйл	20	204	2025 онд 27 байгууллагын 204 ширхэг түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийг сэргээн засварласан.
71707 Соёлын бүтээлч үйлдвэрлэл			
Нийт хөдөлмөр эрхлэгчдэд соёлын салбарт ажиллагчдын эзлэх хувь	20	9.5	2025 оны байдлаар нийт ажиллагч 1,355,667 байгаагаас урлаг, үзвэр, тоглоом, наадгайн салбарын ажиллагч 128,800 нь нийт ажиллагчдын ойролцоогоор 9.5%-ийг эзэлж байна.

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2025 оны статистик мэдээ

3.5.5 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн дансанд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 788.5 сая төгрөг, Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгөөс 11,649.0 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт туссан хөрөнгөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 21,175.5 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 18,345.1 сая төгрөг нийт 51,958.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, хөрөнгийн зардалд 229.1 сая төгрөг, урсгал зардалд 41,550.4 сая төгрөг зарцуулж, 10,407.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл

Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад 435,438.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 125,564.5 сая төгрөгийн 48 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлагдаж, гүйцэтгэлээр 95,258.1 сая төгрөгийн санхүүжилт олгон, 75.9 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын нийт 975.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй, 6 төсөл арга хэмжээний тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Гүйцэтгэлээр 728.6 сая төгрөгийн

гэрээний үнийн дүн бүхий 6 арга хэмжээг хэрэгжүүлж, худалдан авах ажиллагааны тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

-Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй хэвлэл, тохижилт, түрээс, тээвэр зэрэг ижил төрлийн ажил үйлчилгээг нээлттэй тендер сонгон шалгаруулалтгүйгээр, төсөвт өртгийн дээд хязгаарт багтаан хувааж, 2,633.3 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан. /Соёл урлагийн газар 1,438.2 сая төгрөг, БТСУХ 1,002.9 сая төгрөг, Багахангай БТСГ 29.3 сая төгрөг, Нийслэлийн БТСГ 96.3 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн БТСГ 66.6 сая төгрөг, Дуурь бүжгийн эрдмийн театр 527.9 сая төгрөг, Монголын Үндэсний музей 197.9 сая төгрөг, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн 30.0 сая төгрөг, Хүүхэд залуучуудын театр 88.7 сая төгрөг, Уран зургийн галерей 14.6 сая төгрөг/.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтын тогтолцоо, хүний нөөцийн удирдлага, санхүүгийн бүртгэл ба тайлагнал, төсвийн сахилга бат, батлагдсан бүтэц орон тоог нөхөх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Наран, аудитор Т.Нямсүрэн, аудитор Э.Цэлмэгбаяр нар гүйцэтгэж, аудитын үе шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Эрдэнэцэцэг, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 06-ний өдрийн 965 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны төсвийн нийт зарлагын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 415,398.3 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, материаллаг байдлын түвшнийг 4,154.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн урсгал зардлын саналд хуулиар хориглосон, хязгаарласан арга хэмжээг 2025 оны төсвийн төсөлд төлөвлөөгүй ч гүйцэтгэлээр харьяа байгууллагууд төрийн хэмнэлтийн хуулийг зөрчсөн байна.

Харьяа байгууллагуудад хийгдсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 156.2 сая төгрөгийн 10 зөрчил илэрснээс 1.2 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 145.9 сая төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 9.1 сая төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Аудитын илрүүлэлт:

-Төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгийг бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй 18.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна./Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар 1.7 сая төгрөг, Говьсүмбэр сумын Нийтийн номын сан 0.8 сая төгрөг, Дундговь аймгийн Музей 10.2 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн Булган сумын соёлын төв 5.9 сая төгрөг/;

-Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл 2.2 сая төгрөгөөр бэлтгэсэн./Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын соёлын төв 0.7 сая төгрөг, Булган аймгийн Бүрэгхангай сумын соёлын төв 0.3 сая төгрөг, Хөвсгөл аймгийн БТСГ нь 1.2 сая төгрөг/;

Бараа материалын дансанд 17.1 сая төгрөгийн медаль их хэмжээгээр нөөцөлсөн байна. /СХД БТСГ 17.1 сая төгрөг/;

-Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж Биеийн тамир, спортын улсын зөвлөгөөн зохион байгуулж 118.3 сая төгрөг зарцуулсан. /БТСУХ 117.1 сая төгрөг, Дорноговь аймгийн БТСГ 1.2 сая төгрөг /.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийцлийн асуудалтай холбоотой 29,439.1 сая төгрөгийн 205 зөрчил илэрснээс 0.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 19,162.8 сая төгрөгийн 67 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 9,872.5 сая төгрөгийн 132 зөрчилд зөвлөмж өгч, 403.5 сая төгрөгийн 5 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор нийт 16,068.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 15,517.2 сая төгрөгийн 22 албан шаардлага хүргүүлж, 551.3 сая төгрөгийн 53 зөвлөмж өгч, 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Харьяа байгууллагууд

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар нийт 13,370.6 сая төгрөгийн 127 зөрчил илэрснээс 0.3 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4,049.1 сая төгрөгийн 45 зөрчилд албан шаардлага, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан албан хаагчдад хариуцлага тооцуулах 403.5 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 9,321.2 сая төгрөгийн 79 зөрчилд зөвлөмж өгсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагч

Илрүүлэлт 1: Соёлын сайдын 2023 оны А/390 дүгээр тушаалаар баталсан “Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал”-д үр дүнг хэмжих, хэрэгжилтийг үнэлэх, зарцуулалтыг хянах талаар зохицуулалт дутмаг байгаагаас харьяа байгууллагуудын гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих тогтолцоог хэрэгжүүлэхэд хүндрэл учирсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, Соёлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т “Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 22.1.3-т “соёлын статистик мэдээллийг нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийх”, 22.1.6-т “соёлын салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах”, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9-т “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэсэн заалтуудад тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн хуваарилалт, зарцуулалт, хэрэгжилтийн үр дүнд тавих дотоод хяналтыг сайжруулах, мөн "Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал"-ыг зардалд бус хэмжигдэхүйц үр дүнд суурилан Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх.

Илрүүлэлт 2: Жил бүр төвлөрч буй Соёл урлагийн байгууллагууд үндсэн үйл ажиллагааны орлого 5,262.3 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 5,267.4 сая төгрөг олж, үр дүнгийн тайланд тайлагнасан боловч тухайн жилийн төсөвт тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 6.3-т "Энэ хуулийн 5.1.2-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.6.4-т "төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Соёл урлагийн байгууллагууд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж, төсвийг батлуулах.

Илрүүлэлт 3: ССАЖЗСайд Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-тэй байгуулсан төрийн чиг үүрэг гүйцэтгүүлэх гэрээний хүрээнд олгосон 2,447.7 сая төгрөгийн санхүүжилтийн зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, гүйцэтгэгч ТББ нь хуульд заасан хугацаанд үйл ажиллагааны тайлангаа ирүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулаагүй, тендерийн сонгон шалгаруулалтын журмыг мөрдөөгүй зэрэг нь төсвийн хяналтыг сулруулах, ил тод байдал хангагдахгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т "Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо тухайн жилийн үйл ажиллагааны тайлангаа дараа оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ", Төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай гэрээний 3 дугаар зүйлийн 3.2-т "Яам нь гүйцэтгэгчийн үйл ажиллагаа нь холбогдох хууль болон энэ гэрээнд заасны дагуу явагдаж байгаа эсэх, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулж олгосон санхүүжилтийн зарцуулалтад дотоод хяналт шалгалт хийж дүгнэлт гарч, тухайн гүйцэтгэлийг сайжруулах талаар шаардлага тавьж, биелэлтийг хангуулах эрхтэй" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-тэй байгуулсан төрийн чиг үүрэг гүйцэтгүүлэх гэрээний хэрэгжилтийг тооцон, дотоод хяналт хэрэгжүүлж, ил тод байдлыг хангаж ажиллах.

Илрүүлэлт 4: Соёл, урлагийн салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүргийг улсын хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд 9 хууль тогтоомжийг дагалдан гаргах 35 журмыг батлаагүй, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход харьяа, анхан шатны байгууллагаас санал боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй, хяналт, хариуцлагын үр нөлөө бүхий тогтолцоо бүрдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 7.1.2-т "холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хянах", Соёлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрх зүйн орчныг боловсронгуй болгоход харьяа байгууллагуудаас санал авч, боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэх, хууль тогтоомжийг дагалдан гаргах журмыг тоо бус үр дүн, хуулийн хэрэгжилтийг хангуулах талаас анхаарч, хяналт, хариуцлагын үр нөлөө бүхий тогтолцоог бүрдүүлэн ажиллах.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл болон худалдан авах ажиллагаа зэрэг нийцлийн асуудал нь Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар харьяа 29 байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулан, 19,046.4 сая төгрөгийн бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө дансанд биет тооллого хийж, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг төсвийн шууд захирагчид асуудлын бүртгэлээр танилцуулж, жилийн эцэст дахин хянаж шийдвэрлэсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитаар Сөрөг, Татгалзсан дүгнэлт авсан холбогдох албан тушаалтнуудад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах 1 албан шаардлага, Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага хүргүүлж, шийдвэрлэсэнээс хэрэгжилт 67 хувьтай байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Хариуцлага тооцох албан шаардлага	1	-	1	-	100
Албан шаардлага	2	-	1	-	50
Дүн	3	-	2	-	67

/сая төгрөгөөр/

Тайлант оны аудитаар илэрсэн зөрчил нь өмнөх оны аудитаар илэрсэн санхүүгийн зөрчлөөс 129,606.2 сая төгрөг буюу 3.5 дахин өссөн, хэрэгжилт хангалтгүй байгаа тул зөрчлийг таслан зогсоох, дотоод хяналтыг сайжруулах албан шаардлага дахин хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлыг анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ -д төрийн чиг үүрэг гүйцэтгүүлэх хүрээнд олгосон санхүүжилтийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүнг шалгах.
- Урьдчилж гарсан зардал дансны гүйлгээ, үлдэгдлийн үндэслэл болон тайлант үеийн гүйцэтгэлийг шалгах.
- Төрд учруулсан хохиролыг буруутай шийдвэр гаргасан этгээдээр нөхөн төлүүлсэн эсэхийг шалгах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын аудитаар мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой 17,438.3 сая төгрөгийн 101 алдаа, буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой 50,616.5 сая төгрөгийн 353 алдаа, математик тооцоололтой холбоотой 192.5 сая төгрөгийн 14 алдаа, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой 727.6 сая төгрөгийн 26 алдаа, нийт 68,975.0 сая төгрөгийн 494 алдааг төсөв захирагчдын санхүүгийн тайланд залруулж, 2.0 сая төгрөгийн алдааг залруулах 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд буруу тусган илэрхийлсэн 1,504.8 сая төгрөгийн 6 алдааг залруулга хийлгэлээ. Үүнд:

- Дуурь бүжгийн эрдмийн театрын 968.1 сая төгрөгийн татаас, санхүүжилтийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй;
- Харьяаллын бус байгууллага болох "Аялал жуулчлалын үндэсний төв" ТӨҮГ-ийг нэгтгэн тайлагнасан;
- Өвөрхангай аймгийн Уянга сумын соёлын төвийн 1.5 сая төгрөг, Завхан аймгийн Яруу сумын соёлын төвийн 3.6 сая төгрөг, Улсын хүүхэлдэйн театрын 97.1 сая төгрөг, Завхан аймгийн Баянхайрхан сумын соёлын төвийн 9.9 сая төгрөг, Завхан аймгийн Отгон сумын соёлын төвийн 6.8 сая төгрөгийг авлагаар тооцож төвлөрүүлсэн дүнг үр дүнгийн тайлан дээр төвлөрүүлэх шилжүүлгийн зардлаар тооцон бүртгэсэн;
- Хөвсгөл аймгийн Биеийн тамир, спортын газрын орон нутгийн төсвийн данснаас төвлөрүүлсэн 31.6 сая төгрөгийг улсын төсвийн тайлан дээр төвлөрүүлэх шилжүүлгээр бүртгэсэн;
- Улсын хүүхэлдэйн театрын 229.3 сая төгрөг, Үндэсний түүхийн музейн 0.7 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансны өмнөх оны үлдэгдлийг тайлант оны орлогоор Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөр тооцож бүртгэсэн;
- Улсын хүүхэлдэйн театрын 51.9 сая төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайлан дээр эдийн засгийн ангиллыг зөрүүтэй бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" заалттай нийцээгүй, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 1-т "Санхүүгийн тайлангийн толилуулга", "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн аудитын зөрчилтэй холбоотой нийт 165,874.3 сая төгрөгийн 744 зөрчил илэрсэнд 468.8 сая төгрөгийн зөрчилд 151 төлбөрийн акт тогтоож, 34,194.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 256 албан шаардлага, 131,180.8 сая төгрөгийн 334 зөвлөмж өгч, 30.5 сая төгрөгийн 2 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 552.7 сая төгрөгийн 2 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 165,874.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн 497 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдэж 152 байгууллагад дүгнэлт гаргаж, 345 байгууллагын санхүүгийн тайланг аудитын үе шатны ажил хэсэгчлэн гүйцэтгэлээ.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар "Өөрчлөлтгүй" дүгнэлттэй 122 төсөв захирагч, "Хязгаарлалттай" дүгнэлттэй 29 төсөв захирагч, Хөвсгөл аймгийн Биеийн тамир спортын газар нь "Сөрөг" дүгнэлт өгчээ.

5.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

5.2.1 Албан шаардлага

1. Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэлд 2022 онд “Соёлын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж нийлүүлэх” зорилгоор 294,418.2 сая төгрөг, “GLAM системийг хөгжүүлэх, сургалт зохион байгуулах, сурталчилгаа хийх зөвлөх үйлчилгээ үзүүлэх” 224,994.0 сая төгрөгийн гэрээг тус тус байгуулж, гэрээний төлбөрийг бүрэн шилжүүлсэн, ажил, гүйлгээг гүйцэтгэсэн, хүлээлгэж өгсөн эсэх нь тодорхойгүй, гэрээний хугацаа дууссан байхад гэрээ дүгнэсэн актгүй, урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилж гарсан төлбөрийн гүйцэтгэлийг барагдуулах, анхан шатны нотлох баримтад үндэслэн гэрээг дүгнэж, хөрөнгийг бүртгэх, дотоод хяналтыг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

2. Төвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговор 195.4 сая төгрөгийг цалингийн зардлаас олгосон бөгөөд буруу шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтнаас төрд учруулсан хохирлыг төлүүлээгүй байна. /ССАЖЗЯ 50.5 сая төгрөг, БТСУХ 32.3 сая төгрөг, Дуурь бүжгийн эрдмийн театр 14.1 сая төгрөг, Хөвсгөл 42.5 сая төгрөг, Дундговь 5.3 сая төгрөг, Говь-Алтай 51.2 /

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5 заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", 103.2-т "Энэ хуулийн 103.1 заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно" заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь: Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг цалингийн зардлаас олгож, буруу шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтнаас төрд учруулсан хохирлыг төлүүлэх, ажлыг зохион байгуулж шийдвэрлэх албан шаардлага хүргүүлэв.

3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй, санхүүгийн сахилга бат сул байгаагаас тайлант онд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 165,874.3 сая төгрөг, нийцлийн аудитын 29,439.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Зөвлөмж

1. Монгол Улсын аялал жуулчлалын хөгжлийн стратеги боловсруулах чиглэлээр Америкийн Нэгдсэн Улсын "Бостон консалтинг групп"-тэй 2024 онд 1,360,000.0 евро буюу 5,350.0 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээний гэрээг 2 жилийн хугацаатай байгуулж, урьдчилгаа 450,000.0 евро буюу 1,634.1 сая төгрөгийг шууд зардлаар тайлагнасан бөгөөд гэрээний үлдэгдэл төлбөр 910,000.0 евро буюу 3,700.0 сая төгрөгийг шилжүүлэх эсхүл урьдчилгаа төлбөрт дүйцүүлэн гэрээг дүгнэх эсэхийг эцэслэн шийдвэрлээгүйгээс ханшийн зөрүү үүсэх, алданги тооцогдох эрсдэлтэй.

Энэ нь Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т "салбарын хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг боловсруулах, төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх", 7.1.11-т "салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад шаардагдах тооцоо, судалгаа, мэдээ материалыг бусад яам, агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллага, аж ахуйн нэгжээс гаргуулж авах", 7.1.8-д "төрийн албан хаагчдын хэрэгцээг тодорхойлох, тэднийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангахтай холбогдсон бодлого боловсруулж хэрэгжүүлэх" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Монгол Улсын аялал жуулчлалын хөгжлийн стратеги боловсруулах чиглэлээр 2024 онд байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээг дүгнэх асуудлыг эцэслэн шийдвэрлэх.

2. Бусад эргэлтийн хөрөнгө дансанд санхүүжилт авсан боловч дуусгаагүй царцсан барилга, өмнөх онуудад улсын комиссын дүгнэлт гарч, ашиглалтад оруулсан барилга байгууламж, тоног төхөөрөмжийг эрх бүхий байгууллага албан тушаалтнаар шийдвэр гаргуулан ашиглагч байгууллагад шилжүүлээгүй зөрчил харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 120,582.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Салбарын хэмжээнд хөрөнгийн ашиглалт хамгаалалт, бүртгэлийн асуудалд дотоод хяналтыг сул, тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 287 дугаар "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам" -ын 5.5.1-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ", 5.5.3-т "өмчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлсон шийдвэрийн дагуу төрийн өмчийн бүртгэлийн нэгдсэн системд бүртгэнэ", ТӨБЗГ-н 271 дүгээр тогтоол хөрөнгө бэлтгэх, шилжүүлэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Бусад эргэлтийн хөрөнгө дансанд хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийг үе шат бүрээр бүртгэх, эрх бүхий байгууллагын шийдвэрээр ашиглагч байгууллагад шилжүүлэх, дотоод хяналтыг сайжруулах.

5.3 Түүврийн байгууллага

5.3.1 Төлбөрийн акт

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хөрөнгө оруулалт, барьцаа

1.Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй хариуцах эзэн холбогдогчгүй 26.2 сая төгрөг, Засгийн газрын 2023 оны 456 дугаар тогтоол, 2024 оны 249 дүгээр тогтоолыг үндэслэн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хэрэгжээгүй 2 хөрөнгө оруулалтын санхүүжилт 45.0 сая төгрөг, нийт 71.2 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2-т “төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлээгүй, барьцаа хөрөнгийн дансанд байршиж буй нийт 71.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх, төлбөрийн акт тогтоолоо.

Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн

2. Өвөр Монголын Өөртөө Засах Орны иргэнтэй хөдөлмөр эрхлэлтийн зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар хөдөлмөрийн гэрээ байгуулан нийт 34.3 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 27 дугаар зүйл “Хууль бус хөдөлмөр эрхлэлтийг хориглох”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөр эрхлэлтийн зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар хөдөлмөрийн гэрээ байгуулан цалин хөлс, урамшуулал, ур чадвар нэмэгдэл, ээлжийн амралтын олговор, унаа хоолны хөнгөлөлтөд нийт 34.3 сая төгрөгийг олгосныг нөхөн төлүүлэх.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын хөтөлбөр арга хэмжээ

4. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 431 дүгээр тогтоолоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн хүрээнд 2023 онд “Аялал жуулчлалын салбарыг дэмжих зээл”-ийн шаардлага хангаагүй 4 аж ахуй нэгжид 7.7 сая төгрөгийн хүүгийн хөнгөлөлтийг олгосон байна.

Энэ нь Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага” гэж байр сууц, тээвэр, хоол үйлдвэрлэл, үзмэр, үзвэр үйлчилгээ, жуулчны мэдээллийн төв зэрэг жуулчинд зориулсан үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдийг”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйл Албан татвараас чөлөөлөх 13.5.14-т “тур оператор, аяллын агент гадаад улсын аялал жуулчлалын байгууллагатай гэрээ байгуулж жуулчдыг нь хүлээн авах, уг үйлчилгээг төлөвлөх, сурталчлах, виз авахтай холбогдсон болон аяллын бусад бичиг баримтын бүрдүүлэлт хийх зэрэг гадаадын жуулчинд үзүүлсэн үйлчилгээ”, МУЗГ-ын 2022 оны 431 дүгээр тогтоолоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн хүрээнд 2023 онд “Аялал жуулчлалын салбарыг дэмжих зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 3.1.1-т “Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн, эсвэл нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдсөн байх”, 3.1.2-т “Монгол Улсын нутаг дэвсгэрт 12 сараас доошгүй хугацаанд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлсэн байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн шалгуур хангаагүй 4 аж ахуй нэгжид олгосон 7.7 сая төгрөгийн хүүгийн хөнгөлөлтийг буцаан төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

5.2.2 Албан шаардлага

1. ССАЖЗ яамны барьцаа хөрөнгийн үлдэгдэл 2,511.5 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8-д “Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжид энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гүйцэтгэгчээс хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу зохицуулна”, мөн Гэрээний тусгай нөхцөлийн 6.6 - д “Барьцаа хөрөнгө нь гэрээний үнийн 5% байна. Ажлын чанарын баталгаат хугацаа 1 жил

гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулсны дараа олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тус яамны барьцаа хөрөнгийн үлдэгдэл 2,511.5 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, цаашид зөрчлийг давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн

2. Тайлант онд нэр бүхий 5 харилцагч байгууллагад 2.9 сая төгрөгийн өр төлбөр үүссэн бөгөөд тооцоо нийлсэн акт үйлдэж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн "Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөр үүсгэсэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах, давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Нэр бүхий 2 хэвлэл мэдээллийн байгууллагатай нэг арга хэмжээний зардлын төсөвт өртгийг хувааж ижил утгатай гэрээний загвараар нийт 30.0 сая төгрөгийн хэвлэлийн эх бэлтгүүлж, худалдан авах ажиллагааны харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоох, давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

4. Тус байгууллагын нягтлан бодогчийн ажлыг улирал бүр дүгнэн, үр дүнгийн мөнгөн урамшууллыг 50.0 хувиар олгосон боловч балансын урамшуулал болох 2 сарын үндсэн цалинтай тэнцэх 3.1 сая төгрөгийг давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т "Онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна", 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж, урамшуулж болно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Урамшуулал давхардуулан олгодог зөрчлийг таслан зогсоох, давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Чингис хааны өв, соёлын хүрээлэн

5. Байгууллагын нягтлан бодогч, нярав нарын ажлыг улирал бүр дүгнэн, үр дүнгийн мөнгөн урамшууллыг 50.0 хувиар олгосон боловч балансын урамшуулал болох 2 сарын үндсэн цалинтай тэнцэх 5,328.0 сая төгрөгийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудад тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урамшуулал давхардуулан олгодог зөрчлийг таслан зогсоох, давтан гарахгүй байх.

Байгалийн шинжлэх ухааны үндэсний музейн ашиглалтын өмнөх захиргаа

6. Улаанбаатар хотын А бүсэд өндөр зэрэглэлийн бүсэд оффисыг байрыг сонгон шалгаруулалт зарлаагүй, харьцуулалтын арга хэрэглээгүй шууд гэрээ байгуулж, 74.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23-т "худалдан авах ажиллагаа" гэж бараа худалдан авах, түрээслэх, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах ажиллагааг төлөвлөх, тендер шалгаруулалтын аргыг сонгох, үнэлгээний хороо байгуулах, тендер шалгаруулалт зохион байгуулах, тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх ажиллагааг, 8 дугаар зүйлийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 33.1-т "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-т заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоох, давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ

7. Тайлант онд урсгал засварын зардалд 50.1 сая төгрөгийг 8-н иргэн, аж ахуй нэгж байгууллагатай төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралт "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-т Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг байна заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоох, давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

8. ТӨБЗГ-ын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшинд тайлант оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас ногдол ашгийн улсын төсөвт төвлөрүүлэх 13.4 сая төгрөгийг төлөвлөсөн хэдий ч, төлөвлөсөн орлого 178.0 сая төгрөгөөр тасарч, 18.2 сая төгрөгөөр алдагдалтай ажилласнаар улсын төсөвт ногдол ашиг төвлөрүүлэх боломжгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ", 11 дүгээр зүйлийн 3-т "төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын

хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох", Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.1-т "төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12.9-д зааснаас бусад төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааны орлогыг тооцоо судалгаан дээр үндэслэн бодитой төлөвлөдөггүй зөрчлийг арилгаж, цаашид зөрчлийг давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаа

9. Нягтлан бодогчийн ажлыг хагас бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшуулал 3.1 сая төгрөгийн цалин хөлс давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж, урамшуулж болно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй.

Шийдвэрлэсэн нь: Урамшуулал давхардуулан олгодог зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

10. Материалын тайлантай холбоотой дансанд нэр төрөл, нэг бүрийн үнэ, тоо хэмжээг өөрчлөн орлого авч зардал гаргасан, шатахуун, арга хэмжээний зардлыг бэлэн мөнгө хүсэх өргөдлөөр олгож, анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангахгүй баримтаар нийт 16.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 14 дүгээр зүйлийн 14.4.5-д "бүх орлого", 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, бөөн дүнгээр зардал гаргасан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Биеийн тамир спортын улсын хорооны хөрөнгө оруулалт

11. ССАЖЗС-ын спортын хөрөнгө оруулалтын бусад эргэлтийн хөрөнгө дансанд биетээр байхгүй, хэзээ хэнд хүлээлгэн өгсөн нь тодорхойгүй 2019 оноос өмнө худалдан авсан 229.0 сая төгрөгийн 214 ширхэг тоног төхөөрөмж, бараа материал бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 5.1.5-т "хэмжигдэхүйц байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах", Засгийн газрын 2023 оны 287 дугаар "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.3.9-д "Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн

дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эзэн холбогдогч нь тодорхойгүй хуучнаар "Биеийн тамир, спортын газар"-ын хөрөнгө оруулалттай холбоотой 228.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн үлдэгдэлтэй байгаа зөрчлийг таслан зогсоох, давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Кино урлагийн зөвлөлийн ажлын алба

12. Төсвийн захирагч нь 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 20 дугаартай албан бичгээр Кино урлагийн зөвлөлийн ажлын алба болон Кино урлагийг дэмжих сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаа хоцроож ирүүлсэн бөгөөд өмнөх оны аудитаар өгсөн санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж, хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлж хэвших гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т зааснаар "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант оны санхүүгийн тайланг хугацаа хоцроож ирүүлдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

13.Өмнөх оны аудитаар байгууллагын ашигладаг <https://filmmongolia.gov.mn/> болон <https://kuds.filmmongolia.gov.mn/auth/login> системүүдийн өртөг тодорхойгүй, бие бус хөрөнгөөр санхүүгийн тайланд бүртгээгүй, санхүүгийн тайланг үнэн зөв гаргаагүй зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т зааснаар "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим системүүдийн өртгийг тодорхойлж, бие бус хөрөнгөөр санхүүгийн тайланд бүртгээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

14. Олон улсын кино наадамд оролцуулах зорилгоор давхардсан тоогоор 15 албан хаагчийг гадаад томилолтоор ажиллуулж, нийт 67.2 сая төгрөгийн томилолтын зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжаас гаргасан. Мөн албан хаагчдыг томилолтоор ажиллуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэрт батлагдсан зардлын төсөв боловсруулж, батлаагүй, томилолтоор ажилласан тухай ажлын тайланг гаргуулаагүй, холбогдох анхан шатны баримтын бүрдэл дутуу санхүүгийн тайланд тусгасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 10 сарын 19-ний өдрийн 190 дүгээр тушаал баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.6 дахь заалт "Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчид томилолтоор ажиллуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр, батлагдсан зардлын төсвийг үндэслэн томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг урьдчилан олгоно", 2.10 дахь заалт "Унааны зардлын баримт (онгоц, галт тэрэг, хот хоорондын нийтийн тээврийн тасалбар, автомашин хөлсөлсөн бол

ажил гүйцэтгэх гэрээ эсхүл шатахуун худалдан авсан тасалбар)-ыг төрийн албан хаагч албан томилолтын тайландаа хавсаргах ба хоолны болон байрны зардлын баримтыг албан томилолтоор ажилласан төрийн албан хаагчаас шаардахгүй байж болно" заалтыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулдаггүй, албан хаагчдыг томилолтоор ажиллуулах тушаал шийдвэрт зардлын төсөв батлуулдаггүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу нягтлан бодох бүртгэл хөтөлдөг зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Кино урлагийг дэмжих сан

15. Тайлант оны кино урлагийг дэмжих сангийн санхүүжилт 250.0 сая төгрөгийг тэнцүү хувааж "эргэн төлөгдөх нөхцөлгүй" болон "эргэн төлөгдөх хөнгөлөлттэй зээл"-д зарцуулах журамтай бөгөөд нийт санхүүжилтийн 89.6 хувь буюу 224.0 сая төгрөгийг "эргэн төлөх нөхцөлгүй" уран сайхны 3 киног санхүүжүүлж, 99.0 сая төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Кино урлагийг дэмжих сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-т "эргэн төлөх нөхцөлгүй олгох санхүүжилт", 12.2.2-т "эргэн төлөгдөх хөнгөлөлттэй зээл олгох", Засгийн газрын 2022 оны 132 дугаар тогтоолоор баталсан "Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкиг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, эргэн төлөх, хяналт тавих журам"-ын 2-т "Сангийн хөрөнгийн санхүүжилтийн хувь, хэмжээ", 2.1-т "Сангийн хөрөнгийг Кино урлагийг дэмжих тухай хуулийн 12.2.1 болон 12.2.2-т заасан санхүүжилтийн хэлбэрт тэнцүү хуваарилж дэмжлэг үзүүлнэ" гэсэн заалтуудад тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь. Кино урлагийн дэмжих санд улсын төсвөөс олгосон санхүүжилтийг журмын дагуу олгогдоогүй зөрчлийг таслан зогсоох

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хөтөлбөр, арга хэмжээ

16. Хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд улсын хэмжээнд зохион байгуулагдах 2 арга хэмжээг гүйцэтгүүлэхээр нэр бүхий 2 хуулийн этгээдтэй нийт 32.0 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан, тус гэрээний хугацаа дууссан боловч, гүйцэтгэсэн ажлын тайлан, ажил дүгнэсэн акт зэрэг анхан шатны нотлох баримтын бүрдэлгүй урьдчилж төлсөн зардалд тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын нэгдүгээр хавсралт "Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ын 2 дугаар зүйлийн 2.3-т "Нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгах мэдээлэл нь хамааралтай байх, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэх боломжтой байх, шалгах боломжтой байх зэрэг чанарын шинжүүдийг хангана", 4 дүгээр зүйлийн 4.1-т "Санхүүгийн байдлын тайлан нь төсвийн байгууллагын хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн үлдэгдлийг тайлагналын өдрөөр тасалбар болгон толилуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилж төлсөн зардлын шинж чанарт нийцээгүй, гэрээний хугацаа дууссан зардлыг урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн зөрчлийг таслан зогсоох, давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

17. Төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, харьцуулалтын арга хэрэглээгүй, 430.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий зүйлсийг хорин сая төгрөгөөс доош үнийн дүнтэйгээр хэсэгчлэн хуваан, 25 аж ахуй нэгжтэй шууд гэрээ байгуулж, арга хэмжээ зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоох, давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

18. Батлагдсан төсөвт тусгагдаагүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүй Аялал жуулчлалын сургалтын төвийн барилгын нээлтийн арга хэмжээний хүрээнд гадна талбайн тохижилт, үзэсгэлэнгийн танхим тохижилт, хогийн сав байрлуулах, хаягжилт, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент зэрэгт нийт 352.9 сая төгрөгийг материалын тайлан бэлтгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн хуулийн хоргилсон заалтыг зөрчин хэвлэл мэдээллийн зардал болон батлагдсан төсөвт тусгагдаагүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүй зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоох, давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

19. Бүсийн сургалт зохион байгуулах, удирдах ажилтны зөвлөгөөнийг улсын хэмжээнд зохион байгуулахтай холбогдуулан албан томилолтын зардал, түрээс тохижилтын зардал, хэвлэлийн зардал, бусад зохион байгуулалтын зардал, нийт 348.8 сая төгрөгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" заалтыг зөрчсөн байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүсийн сургалт зохион байгуулах, удирдах ажилтны зөвлөгөөнийг улсын хэмжээнд зохион байгуулахтай холбоотой арвилан хэмнэлтгүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоох, давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

20. Салбарын хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Аялал жуулчлалын долоо хоног" үндэсний чуулганыг 2025 оны 2 дугаар сард зохион байгуулсан боловч тус арга хэмжээнд шаардагдах 300.0 сая төгрөгийн зардлыг 2025 оны 4 дүгээр сард Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталж, ажил гүйцэтгэх гэрээг Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-тэй арга хэмжээ хэрэгжсэний дараа байгуулсан бөгөөд тушаалын хавсралтад тусгагдсан ажил, үйлчилгээтэй зөрүүтэй, улмаар төсөв батлах, гэрээ байгуулах, гүйцэтгэлийг баримтаар нотлох үйл ажиллагаа нь цаг хугацааны хувьд алдаатай, дотоод хяналтгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-т "иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой хөтөлбөр, арга хэмжээг тэдгээрээр гүйцэтгүүлэх чиглэл баримтлах", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Салбарын хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Аялал жуулчлалын долоо хоног" үндэсний чуулганы арга хэмжээнд дотоод хяналт хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох, давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

21. Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд зардлаар хүлээн зөвшөөрч, холбогдох төлбөрийг бүрэн санхүүжүүлсэн байна. Үүнд: Сайдын А/169 тушаалаар “Монгол дархны уламжлал, шинэчлэл” үндэсний чуулганд оролцогчид цайны завсарлагаар Coffee break, чуулганы талаар мэдээлэл түгээх, үзэг бал, дэвтэр зарцуулсан, Go Mongolia брэндийг гадаадын олны танил нөлөөлөгчийн хамт олон улсад сурталчлах зорилгоор гадаад зочны утасны сим, нэгжийн төлбөр, хамгаалалтын үйлчилгээ, унаа түрээс, үйл ажиллагааны зардал, Гадаад улсаас Монгол Улсад хийсэн төрийн өндөр, дээд хэмжээний айлчлалын хүрээнд хамтарсан соёлын өдөрлөг, урлагийн тоглолт зохион байгуулахад нийт 157,3 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.3.1-т "анхан шатны баримт бүрдүүлэх" заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд зардлаар хүлээн зөвшөөрч, холбогдох төлбөрийг бүрэн санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоох, давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хөрөнгө оруулалт их засвар

Бусад эргэлтийн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

1. Бусад эргэлтийн хөрөнгө дансанд хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийг үе шат бүрээр бүртгээгүй, 2 буюу түүнээс дээш жил болсон, хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөөтэй эсэх нь тодорхой бус нийт 347,041.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.8-д Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд "Хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнана" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Бусад эргэлтийн хөрөнгө дансанд хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийг үе шат бүрээр бүртгэх.

2. Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 1,031.0 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр холбогдох соёлын байгууллагуудад хуваарилаагүй, зориулалтын дагуу ашиглалтад тавьж олгоогүйгээс эдийн засгийн үр өгөөжийг хүртэх боломжгүй байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 287 дугаар "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам" -ын 5.5.1-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Бусад эргэлтийн хөрөнгө дансанд бэлтгэсэн тоног төхөөрөмжийг эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулж, салбарын соёлын байгууллагуудад хуваарилах.

3. Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт хэрэгжүүлээгүй, явцын тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргүүлээгүйгээс 9,015.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.8-д Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд "Хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнана" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Арга хэмжээний хэрэгжилтийг улирал тутам тайлагнах, биелэлтийг цаг тухайд нь гаргах.

4. Өмнөх оноос шилжиж ирсэн нийт 9,432.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээг тайлант онд 3,923.5 сая төгрөг санхүүжүүлэхээр баталсан ч тайлант онд санхүүжилт олгоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Өгсөн зөвлөмж: Төсөл арга хэмжээг ач холбогдол, эдийн засгийн үр нөлөөгөөр эрэмбэлж, төсвийг бодитой төлөвлөж, санхүүжүүлэх.

Соёл урлагийг дэмжих сан

Орлоготой холбоотой асуудал

5. ССАЖЗ-ын салбар нь татварын орлого төвлөрүүлдэггүй, өөрийн үйл ажиллагаа, гүйцэтгэлд суурилсан нэмэлт санхүүжилтийн орлогоос бүрдэх тул олон улсын сайн жишигт үндэслэн орлогын эх үүсвэрийг бий болгох, соёлын өв, дижитал бүтээгдэхүүн, лиценз болон мерчандайзийн талаарх зохицуулалттай холбоотой эрх зүйн шинэчлэл хийснээр улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой бөгөөд тусгай сангийн өөрийн үйл ажиллагаанаас олох орлогын эх үүсвэр, зардлыг төлөвлөж, батлуулаагүй байна.

Энэ нь Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-т "Энэ хуулийн 15.4-т заасан эрх бүхий байгууллага соёлын үнэт зүйлийн загварыг ашиглуулснаас бий болсон орлогын тодорхой хувийг ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийн 5.3.13-т заасан Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих санд төвлөрүүлж, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ, инновац, технологийн судалгаа, хөгжүүлэлт, бизнесийн зөвлөх үйлчилгээ, мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх сургалтад зарцуулна", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2.-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх" заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Соёлын үнэт зүйлийн загварыг ашиглуулан кино урлагийн сангийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах.

Чингис хааны өв, соёлын хүрээлэн

Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

6. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 41 ширхэг 54.7 сая төгрөгийн хөрөнгийг ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3-ийн 1-т "худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө хөрөнгийг ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх.

7. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Кембрижийн их сургуулийн Нийгмийн антрологийн тэнхимийн Монгол ба Өвөр Ази судлалын төвтэй хамтран байгуулсан “Чингис хаан судлалыг хөгжүүлэх чиглэлээр судалгааны тэтгэлэг олгох гэрээ”-ний үндсэн дээр Төрөөс иргэдэд олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлаас санхүүжүүлсэн өмнөх оны урьдчилан гарсан 341.6 сая төгрөгийн зардал байна. Гэвч гэрээнд заасан судалгааны ажлыг Кембрижийн их сургуулийн холбогдох судлаачид Монгол Улсад ирж гүйцэтгээгүй бөгөөд мөн гэрээнд заасан жилийн тайланг ирүүлэх үүргийг биелүүлээгүй байна. Иймд дээрх нөхцөл байдлаас шалтгаалан 2025 оны төсөвт суулгасан 350.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлээгүй.

